

# БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

- ГАЗАР ОЛГОЛТ, ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ОРЛОГОД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС ЗОРИУЛАЛТ БУСААР БУСДАД ШИЛЖҮҮЛЭХ ЭСРДЭЛ ҮҮСЭЭД БАЙНА.
- ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЦЭЭНД ЗАЙЛШГҮЙ ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫГ ХУУЛЬД НАРИЙВЧЛАН ЗОХИЦУУЛААГҮЙГЭЭС ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛАХГҮЙГЭЭР ҮР ДҮНГҮЙ ЭЗЭМШИЖ БАЙНА.

**АУДИТЫН СЭДЭВ: ИРГЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
ЭЗЭМШЛИЙН ЗОРИУЛАЛТААР ОЛГОСОН ГАЗАР,  
АШИГЛАЛТЫН ҮР ДҮН**

**АУДИТЫН КОД: БУА-2025/34-ШТА-ГА**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. [bulgan@audit.gov.mn](mailto:bulgan@audit.gov.mn)

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор Д.Багцогт  
Утас: 7034-2580 Цахим хаяг: [Baftsogtd@audit.gov.mn](mailto:Baftsogtd@audit.gov.mn)  
Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 7034-2716 Цахим хаяг: [Enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Г.Намчинсүрэн  
Утас: 7034-2495 Цахим хаяг: [Namechinsureng@audit.gov.mn](mailto:Namechinsureng@audit.gov.mn)  
Аудитор: Г.Цэрэнлхам  
Утас: 7034-2495 Цахим хаяг: [Suvdaa@audit.gov.mn](mailto:Suvdaa@audit.gov.mn)



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ**

2025 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/31

Булган сум

**Аудитын тайлан баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам" 2020 оны А/106 дугаар тушаалын 18.9, "Эрх шилжүүлэх тухай" 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Иргэн хуулийн этгээдийн эзэмшлийн зориулалтаар олгосон газар, эзэмшилт, ашиглалтын үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар, аймаг, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нарт болон Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Намчинсүрэн)-д даалгасугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга (Ж.Ганболд), Засаг дарга (Д.Пүрэв-Очир), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн), сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.

4.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Булган аймаг дахь Төрийн аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Намчинсүрэн)-д үүрэг болгосугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитын менежер (Ж.Энхцоодол)-д даалгасугай.

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
ХУУЛБАР ҮНЭН  
Хуулбар олгосон аудитын тухай  
20... оны 12 сарын 15 ны өдөр

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТЦОГТ

ТУ25573 0425060026 3190269

6325010019

## Агуулга

Товчилсон үгийн тайлбар.....	17
Хүснэгтийн товъёг .....	17
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ .....	18
<b>А.1 Сумдын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө аймгийн газар     зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан     байна.</b> .....	21
<b>А.2 Гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газар олгохдоо хуулиар     тогтоосон хэмжээг хэтрүүлэн эзэмшүүлсэн байна.</b> .....	24
<b>Б.1 Эзэмшүүлэхээр олгосон газарт хуульд заасан хугацаанд зарим нэгж     талбарыг ашиглаагүй, хөрөнгө оруулалт хийгдээгүй байна.</b> .....	29
<b>Б.2 Газрын төлбөрийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй, өрийн     үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, төрийн     байгууллагууд хоорондын уялдаа холбоо муу ажиллаж байна.</b> .....	33
<b>В.1 Газар олголт, газрын төлбөрийн орлогод тавих хяналт хангалтгүй байна.</b> .....	36
<b>В.2 Зарим сумууд газартай холбоотой зөрчлийг арилгах арга хэмжээг     тодорхой түвшинд хэрэгжүүлэн ажиллаж байна.</b> .....	38
ДҮГНЭЛТ:.....	44
ЗӨВЛӨМЖ: .....	46

**Товчилсон үгийн тайлбар**

АДБОУС	Аудитын байгууллагын олон улсын стандарт
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилгаа хот байгуулалтын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ШТА	Шууд тайлагнах аудит
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

**Хүснэгтийн товьёг**

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө, гүйцэтгэл /2023, 2024/	8
Хүснэгт 2	Гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан эзэмшүүлсэн газар /2023, 2024/	10
Хүснэгт 3	Гэр бүлийн хамтын хамтын хэрэгцээнд хууль заасан хэмжээнээс илүү хэмжээгээр эзэмшүүлсэн газар	11
Хүснэгт 4	Төрийн байгууллагад эзэмшүүлсэн газрын мэдээлэл /га/	12-13
Хүснэгт 5	Төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлсэн газар /2023, 2024/	13
Хүснэгт 6	Эзэмшүүлэхээр олгогдсон газрын төлөв /аймгийн хэмжээнд/	15
Хүснэгт 7	Газрын төлбөрийн орлогын нэмэгдүүлэх боломжийн судалгаа	18
Хүснэгт 8	Эрх шилжүүлсний орлогыг өмнөх онтой харьцуулалт	21

**Дүрслэлийн товьёг**

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	16
Дүрслэл 2	Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөний биелэлт	19

**Хавсралтын товьёг**

№	Тайлбар
Хавсралт 1	Газар зохион байгуулалтын төлөвлөгөө гүйцэтгэл /2023, 2024/
Хавсралт 2	Гэр бүлийн хамтын хэрэгцээнд эзэмшүүлсэн газар /2023, 2024/
Хавсралт 3	Төсөвт байгууллагад эзэмшүүлсэн газар /аймгийн нийт дүн/
Хавсралт 4	Дуудлага худалдаагаар эзэмшүүлсэн газар /2023, 2024/
Хавсралт 4	Сумдын дуудлага худалдаагаар эзэмшүүлсэн газар /2023, 2024/
Хавсралт 5	Гэрээнд заасан газрын зориулалт /аймгийн нийт дүн/

**АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ****Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МУЕА-ын 2024 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн хийлээ.

**Аудитын зорилт**

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон жилийн төлөвлөгөөний дагуу эзэмшлийн газар олголт ил тод үр дүнтэй хийгдсэн эсэх
- Олгосон газрыг зориулалтын дагуу, эзэмшиж ашиглаж, газар эзэмшихтэй холбоотой газрын төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлсэн эсэх;
- Газар эзэмшилт, ашиглалтад тавих хяналт үр дүнтэй эсэх;

**Аудитын хамарсан хүрээ**

Аудитад Газрын тухай хууль болон Газрын төлбөрийн тухай хуулийн хүрээнд газар эзэмшүүлэх шийдвэр, газрын төлбөрийн орлогын ногдуулалт, бүрдүүлэлтийн талаар чиг үүрэг хүлээсэн төрийн байгууллага болох аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, аймаг, сумдын ЗДТГ, Орон нутгийн өмчийн газар, Татварын хэлтэс, ГХБХБГ-ын 2023-2024 оны эзэмшлээр олгосон газар олголт, газрын төлбөрийн ногдуулалт, бүрдүүлэлттэй холбоотой үйл ажиллагааг хамруулав.

Аудитын явцад сумдын газрын даамал болон, сумын газрын даамалгүй сумдын газар, төлөвлөлт, үйл ажиллагааг түүвэрлэн газар дээр нь шалгасан.

**Аудитын арга зүй,**

Аудитыг АДБОУС 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудит”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-д заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад дурдсан мэдээлэлд судалгаа, шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тодруулга авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, үр дүнг тооцох арга зүйг ашиглалаа.

**Аудитын  
шалгуур  
үзүүлэлт**

Аудитыг Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг ашиглан дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол хийж, ахлах аудитор Г.Намчинсүрэн, аудитор Г.Цэрэнлхам нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудитыг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл гүйцэтгэж аудитыг үе шатны хяналтаар хянуулж аудитын тайланг хавсралт судалгааны хамт 2025 оны 11 дүгээр сарын 25-ний өдөр аймгийн Засаг дарга, аймгийн ИТХ, аймгийн ГХБХБГ-т тус тус хүргүүлэн ажилласан болно.

**Хүндрэл  
бэрхшээл**

Аудитыг гүйцэтгэх үе шатанд land менежер цахим системд нэвтэрч нэгж талбарын ашиглалт, зориулалтыг нягтлан шалгахад интернетын хурд гүйцэхгүй 1 нэгж талбарыг нягтлан шалгахад 2-5 минут зарцуулагдаж байсан ба зарим газар олголтын хэрэгжилтийг цаасан нотлох баримтын хүрээнд хянасан.

**ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:**

Аймгийн ГХБХБГ нь Газрын тухай багц хууль, салбарын бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэхэд анхаарч, Газрын цахим шилжилт Монгол улсын хэмжээнд нэвтэрсэнтэй холбогдуулан төрийн үйлчилгээний цахим систем [www.emongolia-d](http://www.emongolia-d) нэгдэн [www.egazar](http://www.egazar) ийг ашиглаж 16 сум, 1 тосгоны хэмжээнд цахим үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна.

Мөн төрөөс газрын талаар баримталж буй бодлого чиглэлтэй уялдуулж, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор улсын хэмжээнд хэрэглээнд нэвтэрсэн газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааг эрхлэх ажлын хүрээнд:

- Хаягийн мэдээллийн систем,
- Газар зохион байгуулалт төлөвлөлтийн цахим систем
- Газрын кадастрын систем
- Газрын үнэлгээний систем зэрэг 4 үндсэн дэд системүүд дээр ажиллаж байна.

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн аймгийн ИТХ-ын 2022 оны IX/18 дугаар тогтоолоор, мөн сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж сумдын ИТХ-р тус тус батлуулан газар зохион

байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулан баталгаажуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Булган аймаг нь нийт 4,873,300 га талбай бүхий нутаг дэвсгэртэй, үүний 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим системд 26988 иргэн, хуулийн этгээд 124,370.4 га газрыг эзэмшиж ашиглаж байна. Газрын нэгдмэл сангийн 5 үндсэн ангиллаар задлан харуулбал:

**Газрын нэгдмэл сангийн ангилал**

Д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	Газрын хэмжээ (га)	Эзлэх хувь
1	Хөдөө аж ахуйн газар	2,760,117	56.64
2	Хот тосгон, бусад суурин газар	40,289	0.83
3	Зам, шугам сүлжээний газар	10,513	0.22
4	Ойн сан бүхий газар	1,971,221	40.45
5	Усны сан бүхий газар	91,160	1.87
	Нийт дүн	4,873,300	100.00

Эх сурвалж: Газрын цахим мэдээллийн нэгдсэн сан

**Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл**

Газрын төлбөрийн орлогын төрөл	2023		Зөрүү	Хувь	2024		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Газрын төлбөр	1,515.3	1,241.4	273.9	81.9	1,602.5	1,366.50	236.00	85.2
Дуудлага худалдаа	540.0	917.1	(377.1)	169.8	602.0	1,058.1	- 456.1	175.7
<b>Нийт дүн</b>	<b>2,055.33</b>	<b>2,158.58</b>	<b>(103.2)</b>	<b>105.0</b>	<b>2,204.5</b>	<b>2,424.60</b>	<b>- 220.1</b>	<b>109.9</b>

Эх сурвалж: Булган аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**БҮЛЭГ 1. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ДҮРЭМД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН Ч ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГААГҮЙ ЗАРИМ ГАЗРЫГ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖААР ОЛГОСОН БАЙНА.**

*Сумдын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан байна.*

1.1 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 3.7.4.4, Газрын тухай хуулийн 25.3<sup>1</sup>-д заасны дагуу Булган аймаг 2022 онд “**газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө**”-г боловсруулж баталжээ.

1.2 Жил бүр аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн сум бүр газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2<sup>2</sup>, 25.3 дахь хэсэгт заасны дагуу сумын ИТХ-ын тогтоолоор батлуулсан байна.

1.3 Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолоор батлагдсан “Газар зохион байгуулалт хийх журам”, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.7.4-т сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхээр тусгагдсан.

1.4 Аймгийн хэмжээнд 2024 оны байдлаар сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө төлөвлөгөөтэй 15 сум, Сэлэнгэ сумын төлөвлөгөөний хугацаа дууссан байна.

1.5 Газрын тухай хуулийн 23.4.1<sup>3</sup>-д заасны дагуу газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний төслийг тухайн сумын газрын даамал боловсруулна гэж заажээ.

1.6 Аудитын явцад зарим сумдын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулсантай танилцахад хийж гүйцэтгэсэн ажлын холбогдох баримт, нотолгоо байхгүй, шийдвэрийн хэрэгжилтэд тавих удирдлагын хяналт, дотоод зохион байгуулалт сул, хангалтгүй байна. (Бугат, Хангал, Орхон, Могод, Бүрэгхангай, Хишиг-Өндөр сумууд) Тухайлбал:

- Газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа ажлын хэсгийг байгуулсан боловч ажлын хэсгийн удирдамжийг холбогдох албан тушаалтнаар батлуулаагүй;
- Тухайн багийн аж ахуй нэгж, байгууллага, иргэд, малчдын бүлэг, малчдын саналыг багийн түвшинд нэгтгэх, багийн зүгээс нэмж оруулах саналыг тусгах, багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж санал аваагүй;
- Жилийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийн гүйцэтгэсэн ажлын тайлан байхгүй;
- Газрын даамалгүй сумдын хувьд мөн холбогдох баримт, материал байхгүй;

<sup>1</sup> Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь энэ хуулийн 25.2-т заасан хүрээнд боловсрогдсон 12-16 жилийн хугацаанд хэрэгжүүлэх зураг төслийн баримт бичиг байна

<sup>2</sup> 20.1.2.тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлах;

<sup>3</sup> 23.4.1.сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулах;

- Газар зохион байгуулалтын нэгдсэн системд оруулсан сумдын ИТХ-ын газар зохион байгуулалтын тухайн жилийн баталсан төлөвлөгөөнд эзэмшүүлэх байршил, газрын нэр алдаатай тусгагдсан;

1.7 Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг бодит хэрэгцээ буюу иргэдийн оролцоог хангаж төлөвлөхгүй байгаа нь иргэд аж ахуй нэгжүүдийн эсэргүүцэл, гомдол маргаан үүсэх, олон нийтийн итгэл алдагдах эрсдэлтэй байна.

1.8 Иймд цаашид сумын газрын даамал жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулахдаа ажлын удирдамж батлуулан, гүйцэтгэсэн ажлын тайланг иргэд олон нийтийн санал оролцоог хэрхэн яаж хангасан, саналыг нэгтгэсэн дүн шинжилгээ хийж баримтжуулан ажиллах шаардлагатай байна.

**Газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний биелэлтийг зарим сумд сумын ИТХ-аар хэлэлцүүлэн дүгнүүлээгүй байна.**


1.9 Аймгийн хэмжээнд 2023, 2024 онуудад газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийт 9197 байршилд 153.5 мянга га талбай бүхий газрыг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар нийт 5842 байршилд 139.5 га талбай бүхий газрыг өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулах, нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 1-т үзүүлэв)

<b>Хүснэгт №1 Газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө, гүйцэтгэл</b>					
Он	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Хэрэгжилтийн хувь
	нэгж талбарын тоо	Нийт талбайн хэмжээ (га)	нэгж талбарын тоо	Нийт талбайн хэмжээ (га)	
2023 он	5900	124,239.25	4288	111,937.51	79.9
2024 он	3277	29,293.00	1554	27,653.50	47.1
<b>Нийт дүн</b>	<b>9177</b>	<b>153,532.25</b>	<b>5842</b>	<b>139,591.01</b>	

Эх сурвалж: Газрын цахим мэдээллийн нэгдсэн сан

1.10 2024 оны газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд нийт 3277 нэгж талбарт 29293 га газар өмчилж, эзэмшүүлэхээр төлөвлөсөн нь өмнөх оны төлөвлөлтөөс 2623 нэгж талбар буюу 94946 га талбайгаар бага, гүйцэтгэлийн биелэлт оноос 31.6 хувиар буурч 47.4 хувьтай байна.

**Дүрслэл №1 Сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь**



1.11 Газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийхэд газрын нэгдмэл сангийн зориулалтаар 2023, 2024 онуудад зарим сумын үзүүлэлт өссөн ч нийт биелэлт 50-60 хувийн түвшинд байна.

1.12 Аудитын хамрах онуудын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт хангалтгүй байгаа шалтгаан нь төлөвлөсөн нийт 5898 нэгж талбарын 50 хувь буюу 2893 нэгж талбарын 186.4 га нь гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар эзэмшүүлэхээр, 31 хувь буюу 1764 нэгж талбарын 209.5 га нь гэр, орон сууцны хашааны газар өмчлүүлэхээр, 10 хувь буюу 589 нэгж талбарын өвөлжөө, хаваржааны газар төлөвлөгдсөн бөгөөд хэрэгжилт нь 50 хувиас доош биелэлттэй байна.

1.13 Мөн сумдын газрын даамлууд нь газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа иргэдийн хүсэлтэд дүн шинжилгээ хийдэггүй, газар эзэмших хүсэлт өгсөн иргэд шаардлагатай баримтуудыг бүрдүүлж хүсэлтээ өгдөггүй, орон нутгаас барьж буй бодлого шийдвэр, иргэн хуулийн этгээдийн хүсэлтийг хангах зорилгоор иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийг давуулан төлөвлөдөг зэргээс шалтгаалан газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө бүрэн хэрэгждэггүй байна.

1.14 Цаашид газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, явцын хяналтыг сайжруулах ажлыг сумдын Засаг дарга, аймгийн ГХБХБГ-аас зохион байгуулах шаардлагатай байна.

1.15 Газрын тухай хуулийн 20.1.1<sup>4</sup>-, 57.1<sup>5</sup>-д ИТХ-аар батлуулсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг тухайн шатны ИТХ-аар дүгнүүлэхээр заажээ.

1.16 Сумдын ИТХ нь гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэх зохицуулалттай бөгөөд Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- Газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний биелэлтийг зарим сумдын хувьд газрын даамал байхгүй гэсэн шалтгаанаар сумын ИТХ-аар хэлэлцүүлж дүгнүүлээгүй (Баян-Агт, Дашинчилэн, Могод);
- Сумын Засаг даргын өргөн мэдүүлсэн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлахдаа Газрын тухай хууль тогтоомжийг зөрчин хуульд заасан хэмжээнээс илүү, дуудлага худалдаа явуулж эзэмшүүлэх газрыг төсөл сонгон шалгаруулалтаар олгохоор баталсан;
- Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих арга хэмжээ зохион байгуулдаггүй;
- Жилийн эцсийн хуралдаанаар тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн сонсож, дүн шинжилгээ хийдэггүй;

<sup>4</sup> 20.1.1.газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж дүгнэх;

<sup>5</sup> 57.1-д "Газрын нэгдмэл санг эзэмших, ашиглах, хамгаалах болон газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд Засгийн газар, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дагуу хяналт тавина"

- Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдаагүй шалтгаан нөхцөлийг тодорхойлдоггүй;

1.17 Иймд сумдын ИТХ-д тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлахдаа Газрын тухай хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, газар эзэмших, ашиглахтай холбогдуулан гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд тавих хяналтыг сайжруулах, энэ талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж дүгнэж ажиллах шаардлагатай байна.

**Гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газар олгоходоо хуулиар тогтоосон хэмжээг хэтрүүлэн эзэмшүүлсэн байна.**

1.18 Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу тухайн орон нутгийн Засаг даргын захирамжаар Монгол Улсын иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан, тус зүйлд заасан хэмжээгээр газар эзэмшүүлэх зохицуулалттай.

1.19 Аудитын хамрах хугацаанд Засаг даргын захирамжаар аймгийн хэмжээнд нийт 1447 нэгж талбарт 740 га газрыг гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэх шийдвэр гаргажээ. Гэр бүлийн хамтын хэрэгцээнд хүснэгт 2-т үзүүлсэн зориулалт, хэмжээгээр газар олгожээ.

**Хүснэгт №2 Гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан эзэмшүүлсэн газар**

Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан эзэмшүүлсэн газрын зориулалт	2023		2024		Нийт	
	нэгж талбар тоо	талбайн хэмжээ (га)	нэгж талбар тоо	талбайн хэмжээ (га)	нэгж талбар тоо	талбайн хэмжээ (га)
гэр, орон сууцны хашааны зориулалтаар эзэмшүүлэх газар	592	42.9	132	10	724	52.7
Давуу эрхээр эзэмшүүлэх тариалангийн газрын төлөвлөлт						
Төмс, хүнсний ногооны усалгаагүй тариалан	13	10.4	10	11	23	21.0
Жимс, жимсгэнийн усалгаагүй тариалан	1	0.8			1	0.9
Тэжээлийн ургамлын усалгаагүй тариалан	38	229.4	70	184	108	413.5
Өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэх	383	171.3	208	81	591	251.9
<b>Нийт дүн</b>	<b>1027</b>	<b>455.0</b>	<b>420</b>	<b>285</b>	<b>1447</b>	<b>740.0</b>

Эх сурвалж: Газрын цахим мэдээллийн нэгдсэн сан

1.20 Газрын тухай хуульд тус хуульд 29 дүгээр зүйлийн 29.1-т “Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар 0.07 га”, 29.2-т “хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар 0.1 га” -аас илүүгүй газрыг тус тус үнэ төлбөргүй эзэмшүүлэх, уг хэмжээнээс илүү олгох тохиолдолд дуудлага худалдаа, төсөл шалгаруулалтын зарчмаар шийдвэрлэхээр заасан.

1.21 Аудитын хамрах хугацаанд гэр бүлийн хамтын хэрэгцээнд үнэ төлбөргүй эзэмшүүлэх шийдвэр гаргаж эзэмшүүлэхдээ Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2<sup>6</sup> дахь заалтыг зөрчин нийт 145 нэгж талбарт 209.4 га газрыг олгосон

<sup>6</sup> энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх

байна. Холбогдох хуулийн заалтыг зөрчин хүснэгт 3-т үзүүлсэн хэмжээгээр аудитад хамрагдах хугацаанд илүү эзэмшүүлжээ. (Дэлгэрэнгүйг хавсралт 2-т үзүүлэв.)

**Хүснэгт №3 Гэр бүлийн хамтын хамтын хэрэгцээнд хууль заасан хэмжээнээс илүү хэмжээгээр эзэмшүүлсэн газар**

Он	Хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар иргэнд 0.07 га-гаас илүү хэмжээтэй эзэмшүүлсэн		Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар иргэнд 0.1 га-гаас илүү хэмжээтэй эзэмшүүлсэн		Иргэдэд давуу эрхээр тариалангийн үр тарианы зориулалтаар 100 га-аас илүү хэмжээтэй эзэмшүүлсэн	
	Тоо	Хэмжээ /га	Тоо	Хэмжээ /га	Тоо	Хэмжээ /га
2023	116	3.98	4	22.3	3	203.3
2024	29	2.1	2	2.6		
Нийт	145	6.08	6	24.9	3	203.3

Эх сурвалж: Газрын цахим мэдээллийн нэгдсэн сан

1.22 Аймгийн хэмжээнд нийт дүнгээр хуульд зааснаас илүү хэмжээгээр гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар үнэ төлбөргүй эзэмшүүлсэн байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 3-д үзүүлэв)

1.23 Газрын тухай хуульд өвөлжөө, хаваржааны газрыг хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газрын ангилалд хамааруулсан зохицуулалттай хэдий ч тухайн зориулалтаар олгох газрын хэмжээ, хэрхэн олгох шалгуур, нөхцөлийг хууль тогтоомжид тодорхой тусгаагүй, өвөлжөө хаваржааны зориулалтаар газар эзэмшүүлэхдээ харилцан адилгүй хэмжээ, нөхцөлөөр шийдвэрлэдэг байна. Тухайлбал: Сумдын өвөлжөө хаваржааны эзэмшүүлэхээр олгосон талбайн хэмжээ 0.06-0.7 га буюу сум бүр өөр өөр хэмжээтэй байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 4-т үзүүлэв)

1.24 Гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан олгосон газраас түүвэрлэн шалгахад хуульд заасан хэмжээнээс илүү олгосон зөрчлөөс гадна дараах зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- 2023 онд жимс жимсгэнэ тариалах газрыг өргөдлийн дагуу давуу эрхээр 0.8 га газрыг эзэмшүүлсэн (Хангал сум);
- Давуу эрхээр эзэмшүүлсэн газар эзэмшүүлэхтэй холбоотой багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлсэн тэмдэглэл, сумын засаг даргад саналыг нэгтгэн хүргүүлсэн баримт, зарим сумдын тухай иргэн холбогдох журамд заасан газар тариалангийн салбарт гурваас доошгүй жил ажиллаж түүний ургацын борлуулалтаас үндсэн орлогоо олж байгаа, түүнчлэн энэ салбарт өмнө нь гурваас доошгүй жил ажиллаж ургацын борлуулалтаас үндсэн орлогоо олдог байсан иргэн гэдгийг нотлох баримт байхгүй (Могод, Бугат сум);
- Давуу эрхээр эзэмшүүлсэн газартай холбоотой баримт мэдээллийг зарим сумд ирүүлээгүй (Рашаант, Хангал, Сэлэнгэ, Хишиг-Өндөр сумд);

зориулалтаар малчдын хоршоонд нэг удаа 5 га хүртэлх газар эзэмшүүлэх асуудлыг аймаг, сум, нийслэлийн Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно.

1.25 Газар эзэмшүүлэх шийдвэр хууль журмын шаардлага хангахгүй байх, ашиглалт хангалтгүй байх, баримт бичгийн архив, бүртгэл дутуугаас маргаан үүсэхэд нотлох баримт дутмаг байх зэрэг эрсдэлтэй байна.

1.26 Цаашид өргөдөл, хүсэлт, хавсралт материалын иж бүрдлийг хангах дээр онцгой анхаарч, үе шатны хяналтыг сайжруулах, газар эзэмшүүлэхтэй холбоотой баримт материалыг нөхөж бүрдүүлэх, нягтлан шалгах ажлыг зохион байгуулж, зөрчилтэй асуудлыг шийдвэрлэж хариу ирүүлэх зөвлөмжийг хүргүүлээ.

**Гэр бүлийн хамтын хэрэгцээнээс бусад газар эзэмшүүлж, ашиглуулах зарим шийдвэр холбогдох хууль журамд нийцээгүй байна.**

1.27 Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2<sup>7</sup>, 33 дугаар зүйлийн 33.1.1<sup>8</sup> -д заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж байгууллагад болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд газар эзэмшүүлэх зохицуулалттай.

1.28 Хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1-д төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газрыг ГЗБ-ын төлөвлөгөөний дагуу тухайн шатны Засаг даргын захирамжаар эзэмшүүлэхээр заасны дагуу 2023, 2024 оны хугацаанд аймгийн хэмжээнд нийт 261 нэгж талбарт 924.6 га талбай бүхий газрыг төрийн байгууллагад эзэмшүүлжээ. Аймгийн хэмжээнд төрийн байгууллагад эзэмшүүлсэн газрыг *дэлгэрэнгүйг хавсралт 5-д үзүүлэв.*

1.29 Холбогдох хууль тогтоомжид “төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газар” гэх ангилалд хамаарах газрын хэмжээ, ашиглалтын зориулалт, тус газар дээр явуулах үйл ажиллагаа зэргийг нарийвчилсан тодорхой зохицуулаагүйгээс төрийн байгууллагын нэрээр ажилчдын зуслан, амралтын газар, амины орон сууц, төмс, хүнсний ногоо тариалах, тэжээлийн ургамлын усалгаагүй тариалан, жимс, жимсгэнийн усалгаагүй тариалан, зэрэг зориулалтаар 0.5-269.6 га хүртэл хэмжээгээр газрыг үнэ төлбөргүй албаны бус хэрэгцээнд эзэмшүүлсэн байна.

#### Хүснэгт-4

#### Төрийн байгууллагад эзэмшүүлсэн газрын мэдээлэл /га/

Сумдын нэрс	2023		2024		Нийт дүн	
	Нэгж талбар	Тайлбайн хэмжээ	Нэгж талбар	Тайлбайн хэмжээ	Нэгж талбар	Тайлбайн хэмжээ
<b>Баян-Агт сум</b>	<b>1</b>	<b>167.6</b>	<b>2</b>	<b>81.4</b>	<b>3</b>	<b>249.0</b>
Тэжээлийн ургамлын усалгаагүй тариалан	1	167.6	2	81.4	3	249.0
<b>Бугат сум</b>	<b>1</b>	<b>5.0</b>	<b>1</b>	<b>0.5</b>	<b>2</b>	<b>5.5</b>
Жимс, жимсгэнийн усалгаагүй тариалан		-	1	0.5	1	0.5
Амины орон сууц	1	5.0		0.0	1	5.0
<b>Булган сум</b>	<b>3</b>	<b>14.3</b>		<b>0.0</b>	<b>3</b>	<b>14.3</b>
Төмс, хүнсний ногооны усалгаатай тариалан	1	10.0		0.0	1	10.0
Тэжээлийн ургамлын усалгаагүй тариалан	1	2.3		0.0	1	2.3

<sup>7</sup> Газар эзэмших эрхийн гэрчилгээг зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгоно.

<sup>8</sup> энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан болон төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газрыг эзэмшүүлэх тухай шийдвэрийг аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу аймаг, сум, нийслэлийн Засаг дарга гаргана;

Аялал, жуулчлалын бааз	1	2.0		0.0	1	2.0
<b>Бүрэгхангай сум</b>		-	7	144.0	7	144.0
Үр тарианы усалгаагүй тариалан		-	7	144.0	7	144.0
<b>Сайхан сум</b>	4	271.1		0.0	4	271.1
Үр тарианы усалгаагүй тариалан	3	269.6		0.0	3	269.6
Амралтын газар	1	1.5		0.0	1	1.5
<b>Тэшиг сум</b>	1	1.0	1	0.1	2	1.1
4 ба түүнээс доош давхар нийтийн орон сууц		-	1	0.1	1	0.1
Амралтын газар	1	1.0		0.0	1	1.0
<b>Хангал сум</b>	1	9.7	1	3.7	2	13.4
Тэжээлийн ургамлын усалгаагүй тариалан	1	9.7		0.0	1	9.7
Амралтын газар		-	1	3.7	1	3.7
<b>Хутаг-Өндөр сум</b>	2	226.1		0.0	2	226.1
Үр тарианы усалгаагүй тариалан	2	226.1		0.0	2	226.1
<b>Нийт дүн</b>	<b>13</b>	<b>694.9</b>	<b>12</b>	<b>229.7</b>	<b>25</b>	<b>924.6</b>

Эх сурвалж: Газрын цахим мэдээллийн нэгдсэн сан

1.30 Дээрх байдлаар дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар олгох зохицуулалтад хамаарах газрыг төсвийн байгууллагын нэрээр үнэ төлбөргүй эзэмшүүлж, бусдад давуу байдал үүсгэж байгаа нь Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан “газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах” зарчимд нийцэхгүй байгаад хяналтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

1.31 Аудитын хамрагдах хугацаанд нийт 31 нэгж талбарт 368.5 га газрыг төсөл сонгон шалгаруулалтаар хуулийн этгээд болон малчдын хоршоонд, 121 нэгж талбарт 559.1 га газрыг иргэн, хуулийн этгээдэд дуудлага худалдаагаар эзэмшүүлсэн байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 6-д үзүүлэв)

#### Хүснэгт№ 5 Төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлсэн газар

Үзүүлэлт	нэгж талбар тоо	талбайн хэмжээ (га)
<b>2023</b>	<b>5</b>	<b>166.2</b>
ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор	3	161.8
ШУ, технологийн сорилт туршилт болон байгаль орчин, цаг уурын талбай	2	4.4
<b>2024</b>	<b>26</b>	<b>202.3</b>
Жимс, жимсгэнийн усалгаатай тариалан	1	100.0
Мал аж ахуйн үйлдвэрлэл	3	5.9
Мал аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах	21	92.2
Тэжээлийн ургамал тариалах	1	4.1
<b>Нийт дүн</b>	<b>31</b>	<b>368.5</b>

Эх сурвалж: Газрын цахим мэдээллийн нэгдсэн сан

1.32 Гэр бүлийн хэрэгцээнээс бусад зориулалтаар иргэн хуулийн этгээдэд газар эзэмшүүлэхтэй холбоотой шийдвэр, баримт материалыг түүвэрлэн үзэхэд дараах нийтлэг зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- Малчдын хоршоонд эзэмшүүлсэн 31 нэгж талбараас “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-ын 2.1.3<sup>9</sup>-д заасныг зөрчин 11 нэгж талбарт 45.3 га газрыг малчдын хоршоонд эзэмшүүлсэн (Могод, Рашаант, Баян-Агт);
- Газрын тухай хуулийн 33.5<sup>10</sup>, “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-ын 3.2<sup>11</sup>-д заасан заалтыг зөрчин жимс жимсгэнэ тарих зориулалтаар 1 нэгж талбарт 100 га (Баяннуур сум), Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор газрын зориулалтаар 3 нэгж талбарт 161.8 га (Бугат сум), ШУ, технологийн сорилт туршилт болон байгаль орчин, цаг уурын талбайн зориулалтаар 2 нэгж талбарт 44.2 га, тэжээлийн ургамал тарих зориулалтаар 4.1 га (Баян-Агт сум) газар эзэмшүүлсэн;
- Аймгийн Засаг даргын захирамжаар газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газрыг эзэмшүүлсэн. (2024 онд Орон нутгийн өмчийн газарт А/348, иргэн Б.Амартүвшинд А/423, 4 төрийн байгууллагад А/738, 2023 онд Булган аймгийн музейд А/246, иргэн П.Хишигдаваад А/478, иргэн Э.Нямдаваа, Ц.Батчимэг, М.Энхтуяа нарт А/711, Дэлгэртэрэм ХХК, иргэн Н.Дэмчигсүрэн, С.Зоригбаатар нарт А/815, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт А/819 тоот захирамжаар газар эзэмшүүлсэн);
- Нийтийн эдэлбэр газар төлөвлөлтөөр 7 нэгж талбарт 2762.4 га газар ердийн хадлангийн газар ашиглуулахаар төлөвлөж иргэдэд ашиглуулахаар гэрээ байгуулж ажиллаж байгаа нь Газрын тухай хуулийн 52.6<sup>12</sup> (Бүрэгхангай сум)-д -ийг хэрэгжүүлж ажиллаагүй;
- Төсөл сонгон шалгаруулахтай холбоотой төсөл хүлээн авсан, шалгаруулалтыг зохион байгуулахтай холбоотой ажлын хэсэг байгуулсан захирамж, ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, малчдын хоршооны хүсэлт, сумын Засаг даргын захирамжаас өөр холбогдох баримт материал байхгүй байгаа нь “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-ын 8, 9 дүгээр зүйлийн заалтад заасан шаардлагыг бүрэн хангаагүй;
- Төсөл сонгон шалгаруулалттай зарим сумд холбогдох баримт материалыг ирүүлээгүй Рашаант, Баян-агт, Хангал сум;
- Эмийн болон гоёлын ургамлын усалгаагүй тариалангийн газрыг дуудлага худалдаагаар олгох газрыг өргөдлийн дагуу давуу эрхээр олгосон. (Сэлэнгэ сум 6302007336);
- 2024 онд жимс жимсгэнэ тариалах газрыг төсөл сонгон шалгаруулалтаар 100 га газрыг эзэмшүүлсэн “Ногоон ази сүлжээ ТББ- 6312002880. (Гурванбулаг сум/

<sup>9</sup> төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх, ашиглуулах газрыг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын болон тусгай бүс, чөлөөт бүс, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд эзэмшүүлэх, ашиглуулахаар заасан байх.

<sup>10</sup> Энэ хуулийн 33.1.2-т заасны дагуу төсөл шалгаруулах хэлбэрээр газар эзэмших эрхийг зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эсхүл мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд, эсхүл гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт зориулж олгоно.

<sup>11</sup> Гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр нь Олон улсын гэрээний тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлаас соёрхон баталсан, эсхүл Засгийн газрын байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрээр баталгаажсан байна.

<sup>12</sup> 52.6.Энэ хуулийн 52.4, 52.5-д заасан газрын хэмжээ болон уг газрыг ашиглуулахтай холбогдсон журмыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

1.33 Дээрх зөрчлүүд нь Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан “газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах” зарчмыг бүрэн хангахгүй газрыг үр ашиггүй эзэмших, төрд итгэх иргэдийн итгэл буурах, хэсэг бүлэг этгээдэд давуу эрхтэй болох эрсдэлтэй байна.

1.34 Иймд Газрын тухай хуулийн 33.1.2<sup>13</sup>-д заасны дагуу эзэмшүүлэх газрын хэмжээ, зориулалт, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

## **БҮЛЭГ 2. ЭЗЭМШҮҮЛЭХЭЭР ОЛГОСОН ГАЗАРТ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНД ЗАРИМ НЭГЖ ТАЛБАРЫГ АШИГЛААГҮЙ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙГДЭЭГҮЙ БАЙНА.**

2.1 Аймгийн хэмжээнд 2025 оны 10 дугаар сарын байдлаар газрыг эзэмших, ашиглах гэрээ байгуулан иргэн, хуулийн этгээдэд 30170 нэгж талбар бүхий газар олгогдсон байна. Эзэмшүүлэхээр олгогдсон нэгж талбарыг нэгдсэн системд бүртгэсэн төлөвөөр нь хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6	Эзэмшүүлэхээр олгогдсон газрын төлөв (аймгийн хэмжээнд)					
	Сумдын нэр	Гэрээний хугацаа дууссан	Төсөл	Хүчинтэй	Шинэчлэх	Нийт нэгж талбар
	Баян-Агт сум	151	6	830	1	988
	Баяннуур сум	59	2	296		357
	Бугат сум	476	27	3,324		3,827
	Булган сум	287	11	2,300	2	2,600
	Бүрэгхангай сум	430	11	706		1,147
	Гурванбулаг сум	202	5	723	2	932
	Дашинчилэн сум	514	4	395	2	915
	Могод сум	466	13	642	2	1,123
	Орхон сум	472	2	3,906	1	4,381
	Рашаант сум	259	12	668		939
	Сайхан сум	109	11	922	1	1,043
	Сэлэнгэ сум	608	10	2,555	1	3,174
	Тэшиг сум	375	25	743	2	1,145
	Хангал сум	2,080	20	2,107	1	4,208
	Хишиг-Өндөр сум	203	10	780		993
	Хутаг-Өндөр сум	560	28	1,602	4	2,194
	Нийт	7,251	197	22,499	19	29,966

Эх сурвалж: Газрын цахим мэдээллийн нэгдсэн сан

2.2 Газар эзэмших, ашиглах гэрээ байгуулан 202.1 мянган га нэгж талбар олгосон газрын 33.6 хувийг өвөлжөө, хаваржаа, өвөл-хаврын бэлчээр, 25.6 хувийг гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар, 12.2 хувийг хөдөө аж ахуйн цогцолбор газар, 9.3 хувийг гэр орон сууцны хашааны газар, 3.3 хувийг худалдаа, нийтийн үйлчилгээний цогцолбор газар, 2.9 хувийг төмс хүнсний ногооны усалгаатай,

<sup>13</sup> энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд нэг удаа 5 га хүртэлх газар эзэмшүүлэх асуудлыг аймаг, сум, нийслэлийн Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно.

усалгаагүй тариалан, 0-1 хувийг гэрээнд заасан бусад зориулалтаар олгосон байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 7-оос үзнэ үү)

2.3 Эзэмшүүлэхээр олгосон газрын 46.8 хувь буюу 14127 нэгж талбар газрыг иргэн, 52.4 хувь буюу 15824 нэгж талбар газрыг хуулийн этгээд эзэмшиж байна.

2.4 Газрын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2<sup>14</sup> дахь зүйл заалтаар 135 төрийн байгууллага 1026 нэгж талбар буюу 3.4 мянган га газрыг эзэмшиж байна. Төрийн байгууллагад эзэмшүүлэхээр олгогдсон нэгж талбар газрыг салбараар нь дүрслэлээр харуулбал:

**Дүрслэл №2 Төрийн байгууллагад эзэмшиж байгаа газрын нэгж талбарын тоо**



Төрийн байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай хамааралгүй дараах зориулалтаар газар эзэмшүүлсэн байна. Тухайлбал:

- Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн зориулалтаар Хангал сумын ИТХ, ЗДТГ, Соёлын төв, Эрүүл мэндийн төв, Хялганат тосгоны Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Цагдаагийн газар нийт 7.2 га буюу 20 нэгж талбар газар;
- Гэр бүлийн хэрэгцээнээс бусад зуслангийн зориулалтаар Шүүхийн тамгын газар, ШШГГ, Прокурорын газар, Онцгой байдлын газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний газар, Цагдаагийн газар, Аймгийн ЗДТГ, Булган сумын ЗДТГ, Эрдмийн өргөө цогцолбор сургууль, Гурванбулаг сумын ЕБС, ЗДТГ, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Хангал сумын ЕБС, хүүхдийн цэцэрлэг, Хутаг-Өндөр сумын ЗДТГ нийт 2,5 га буюу 12 нэгж талбар газар;
- Өвөлжөө, хаваржааны зориулалтаар Баян-Агт, Сэлэнгэ, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын ЗДТГ, Тэшиг сумын Хилийн цэргийн 0286 дугаар анги нийт 2.2 га буюу 9 нэгж талбар газар;
- Төмс, хүнсний ногооны усалгаагүй, усалгаатай тариалангийн зориулалтаар 112.0 га буюу 19 нэгж талбар газар;
- Хүлэмж, дарлагын зориулалтаар Орон нутгийн өмчийн газар 0.9 га буюу 1 нэгж талбар газар;

<sup>14</sup> 28.1.2.төрийн байгууллагын;

- Хүүхдийн зуслангийн зориулалтаар Хишиг-Өндөр, Орхон сумын ЗДТГ, Баян-Агт, Хангал сумын Хялганат тосгон, Хишиг-Өндөр сумын ЕБС 3.7 га буюу 5 нэгж талбар газар;
- Эрчим хүч дамжуулах станцын зориулалтаар Могод сумын ЕБС, Тэшиг сумын ЗДТГазар 0.2 га буюу 2 нэгж талбар газар;

***Аудитаар иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлэхээр олгосон газрын хэмжээ сунгасан, хуулийн хугацаанд хөрөнгө оруулалт хийгдээгүй, зөвшөөрөлгүй хашаа, байшин барьсан зэрэг зөрчил илэрлээ.***

2.5 Нийт 22499 нэгж талбарын 5625 нэгж талбарт санамсаргүй түүврийн аргаар нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээд зориулалтын дагуу хоёр жил дараалан ашиглаагүй, хөрөнгө оруулалт хийгээгүй, зөвшөөрөлгүй газарт дур мэдэн барилга байгууламж барьсан 245 нэгж талбар байна. Тухайлбал:

- Баян-Агт сум 56, Булган сум 133, Орхон сум 47, Хишиг-Өндөр сум 9, Тэшиг сум 13, Бугат сум 36, Хангал сум 61 нэгж талбар газар;

2.6 Эзэмшил газрыг зөвшөөрөлгүй сунгасан, захирамж, гэрчилгээний хэмжээ зөрсөн, мэдээллийн санд мэдээлэл дутуу бүртгэгдсэн зэрэг 186 нэгж талбар газар байна. Тухайлбал:

- Орхон сум 109, Хангал сум 20, Бугат сум 46, Бүрэгхангай сум 11, Баян-Агт сум 2, Тэшиг сум 6, Хутаг-Өндөр сум 16, Хишиг-Өндөр сум 11, Могод сум 3 нэгж талбар газар;

2.7 Газрын бүртгэлийн зөрчлүүд арилахгүй байгаа шалтгаан нь газар эзэмшиж буй иргэд нь өөр аймаг, сум, хот руу шилжсэн, нас барсан, бичиг баримтын зөрчлийг арилгах хүсэлтээ өгдөггүй, зөвшөөрөлгүйгээр захирамжийн дээрх газрын хэмжээнээс илүү эзэмшил газрыг сунган дураараа ашигладаг зэргээс шалтгаалж байна.

***Газрын төлбөрийн орлогыг дутуу ногдуулснаас 2023 онд 216.1 сая, 2024 онд 110.3 сая, өвөлжөө, хаваржааны газраас 39.4 сая төгрөг, нийт 365.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэх боломж алдсан байна.***

2.8 Газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т заасны дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын төлбөрийн тухай хуульд заасны дагуу газрын төлбөр төлөх хуулийн зохицуулалттай.

2.9 Татварын ерөнхий газартай хамтарсан дундын мэдээллийн сангаар дамжуулан Засгийн газрын 2018 оны “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 182 дугаар тогтоол, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2022 оны “Газрын төлбөр ногдуулах аргачилсан заавар батлах тухай” 209 дугаар тушаал, Булган аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны ээлжит 12 дугаар хуралдааны 22 дугаар тогтоолоор баталсан “Газрын төлбөрийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Татварын ерөнхий газартай хамтарсан 2019 оны 173/178 дугаар тушаалаар батлагдсан “Мэдээлэл солилцох журам”, Мэдээлэл харилцан солилцох тухай 2019/09-01/32 дугаар гэрээний дагуу

газрын төлбөрийг дундын мэдээллийн сангаар дамжуулан ногдуулж, төвлөрүүлж байна.

2.10 Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд газар эзэмших, ашиглах хүчинтэй төлөвтэй гэрээгээр 22494 нэгж талбар бүхий 105.9 мянган га газраас 2,155.2 сая төгрөгийн газрын төлбөрийн орлого бүрдүүлэхээр байна.

2.11 Газрын төлбөрийн орлогыг 2024 онд 1,458.8 сая төгрөгийн ногдуулалт хийж, Сумдын иргэдийн төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар 1,348.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулахаар баталсан нь нь өмнөх оноос ногдуулалт 269.5 сая төгрөгөөр, батлагдсан төлөвлөгөө 163.6 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

<b>Хүснэгт №7</b>		<b>Газрын төлбөрийн орлогын нэмэгдүүлэх боломжийн судалгаа</b>					
Д/д	Сумдын нэр	2024 он			2023 он		
		ГТМ-2 мэдээ	Батлагдсан төлөвлөгөө	Алдагдсан боломж	ГТМ-2 мэдээ	Батлагдсан төлөвлөгөө	Алдагдсан боломж
1	Баян-Агт	15,625.2	15,079.6	545.6	15,261.6	14,874.5	387.1
2	Баяннуур	3,947.9	5,070.1	(1,122.2)	3,698.6	3,584.0	114.6
3	Бугат	28,199.7	28,968.2	(768.5)	26,927.6	48,216.3	(21,288.7)
4	Булган	29,824.0	30,165.0	(341.0)	28,327.0	36,152.2	(7,825.2)
5	Бүрэгхангай	734,586.3	799,711.2	(65,124.9)	972,117.9	740,472.9	231,645.0
6	Гурванбулаг	6,467.7	6,307.4	160.3	6,165.6	6,717.6	(552.0)
7	Дашинчилэн	65,181.7	45,812.1	19,369.6	68,058.2	65,367.5	2,690.7
8	Могод	16,162.8	14,248.1	1,914.7	11,305.6	14,595.1	(3,289.6)
9	Орхон	246,270.6	28,256.4	218,014.2	278,099.1	256,332.8	21,766.3
10	Сайхан	11,313.8	10,741.2	572.6	10,578.6	8,129.8	2,448.8
11	Сэлэнгэ	45,649.6	41,117.1	4,532.5	39,338.9	31,247.1	8,091.8
12	Тэшиг	80,906.4	84,331.1	(3,424.7)	83,564.7	90,535.1	(6,970.4)
13	Хангал	60,466.3	115,847.4	(55,381.1)	67,908.2	57,719.4	10,188.8
14	Хишиг-Өндөр	14,351.6	15,524.9	(1,173.3)	6,732.1	12,163.1	(5,431.0)
15	Хутаг-Өндөр	41,988.5	50,704.0	(8,715.5)	49,333.9	50,320.8	(986.9)
16	Рашаант	57,874.8	56,668.9	1,205.9	60,891.9	75,773.3	(14,881.4)
	Нийт дүн	1,458,816.8	1,348,552.7	110,264.1	1,728,309.4	1,512,201.5	216,107.9

Эх сурвалж: Эх сурвалж: Газрын цахим мэдээллийн нэгдсэн сан, ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

2.12 Газрын төлбөрийн орлогын ногдуулалт болон батлагдсан төлөвлөгөө өмнөх оноос буурсан нь цахимаар газрын төлбөрийг ногдуулж, гэрээний хугацаа дууссан, хянан баталгааг хийлгэхэд хугацаа их зарцуулагддаг, иргэн ААН байгууллага, хуулийн этгээдийн нэгж талбар талбайн хэмжээг цахим мэдээллийн санд бүрэн оруулаагүй, газрын гэрчилгээг шинэчлээгүй, улсын бүртгэлийн е дугааргүй газар эзэмшигч, ашиглагчийн газрын төлбөрийн ногдуулалтыг бүрэн тооцож чадахгүй орхигдох зэрэг хүчин зүйлээс нөлөөлсөн байна.

2.13 Аймгийн Статистикийн хэлтсийн мэдээгээр 2024 оны жилийн эцсийн байдлаар 16 сумдын 9538 малчин өрх нийт 14423 дулаан, саравчгүй байр буюу өвөлжөө, хаваржаа бүртгүүлсэн байхад газрын нэгдсэн цахим мэдээллийн санд өвөлжөө,

хаваржааны зориулалттай 10043 нэгж талбарын газар бүртгэгдэж, 4380 өвөлжөө, хаваржааны нэгж талбар газар бүртгэлгүй байна.


2.14 Үүнээс үзэхэд өвөлжөө, хаваржааны зориулалтаар олгогдсон нэгж талбарын гэрээний хугацаа сунгагдахгүй удаашралтай байгаа нь газрын хянан баталгааны хийлгэхэд мэргэжлийн байгууллага цөөн ажиллах хүчний хүрэлцээ хангалтгүй, хугацаа ихээр зарцуулагддаг зэрэг хүчин зүйлээс нөлөөлсөн байна.

2.15 Бүртгэлгүй 4380 ашиглагдаж байгаа өвөлжөө хаваржааны зориулалттай нэгж талбар газраас газрын төлбөрийн орлогыг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа итгэлцүүрээр тооцоход жилд дунджаар 39.4 сая төгрөгийн газрын төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх нөөц боломжийг алдсан байна.

**Газрын төлбөрийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй, өрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, төрийн байгууллагууд хоорондын уялдаа холбоо муу ажиллаж байна.**

2.16 Газрын төлбөрийн ногдлыг ГХБХБГ-ын кадастрын нэгдсэн системийн программд орсон нэгж талбараар, газрын зориулалт, хэмжээгээр ногдуулалт хийж, аймгийн Татварын газар татвар хураан барагдуулах үүргийг батлагдсан журам, зааврын дагуу гүйцэтгэж ажилласан байна.

2.17 Газрын төлбөрийн орлогыг 2024 онд 1,366.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, төлөвлөгөөг 103.1 хувьтай биелүүлсэн нь өмнөх оноос 2.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хувийг дүрслэлээр харуулбал:



2.18 2024 онд Орхон сум “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГазарт 1261.5 га ашиглалт, олборлолт явуулж буй уурхайн зориулалтаар газар эзэмшиж, ашиглах гэрээ хийгдсэн нь газрын төлбөрийн орлогын биелэлт 835.3 хувиар өсөхөд нөлөөлсөн байна.

2.19 Төрийн байгууллагын газар эзэмших, ашиглах гэрээгээр 1026 нэгж талбарт 3,429.3 га газарт 58.2 сая төгрөгийн газрын төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр байна.

2.20 Төсөвт байгууллагуудад эзэмшүүлэхээр олгосон 1026 нэгж талбар газраас Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4<sup>15</sup>, 8.5<sup>16</sup>-д заасны дагуу ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, бүх төрлийн соёлын байгууллагыг болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг байгаль, түүх, соёлын дурсгалт зүйл, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалах, хамгаалахад зориулан эзэмшиж, ашиглаж байгаа нийт 141 нэгж талбар газрын төлбөрийн орлогыг чөлөөлж, 695 нэгж талбарт газарт газрын төлбөрийн орлого ногдуулж, үлдэх 190 нэгж талбарт газрын төлбөрийн орлогын ногдуулалтыг дутуу хийсэн байна.

2.21 Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд 75 байгууллага 2024 оны газрын төлбөрийн авлагын 55.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байхад, жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайланд өглөг тайлагнаагүй байна.

2.22 Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын ногдуулсан газрын төлбөрийн үлдэгдэл 2023 онд 534.8 сая, 2024 онд 52.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3<sup>17</sup>-д заасны дагуу эцсийн тооцоо хийж баталгаажуулдаггүй, төрийн байгууллагууд хоорондоо уялдаа холбоогүй ажиллаж байна.

2.23 Төлбөрийн нэхэмжлэлийг иргэн, хуулийн этгээдэд илгээдэг болсон бөгөөд цахим систем (Egazar.gov.mn, Ebarimt), бүх банкны интернэт банк болон гар утасны аппликэйшн ашиглан түргэн шуурхай газрын төлбөрийн мэдээлэл авах, нэхэмжлэхээр төлбөрөө төлөх боломжийг бүрэн бүрдүүлсэн байна.

***Иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг бусдад шилжүүлэх шийдвэр гаргахдаа хуульд заасан татвар, хураамжийг бүрэн ногдуулаагүй, 159 нэгж талбар газрын эрх шилжүүлсний орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.***

2.24 Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6<sup>18</sup>, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2<sup>19</sup>, хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2<sup>20</sup>- д заасны дагуу газар эзэмших, ашиглах эрхээ бусдад шилжүүлсэн тохиолдолд эрх борлуулсны орлогын албан татвар ногдуулж, төсөвт төвлөрүүлэх үүрэгтэй.

2.25 Булган аймгийн хэмжээнд ашиглах эрхээ 2024 онд 645 нэгж талбарыг шилжүүлэн 99.2 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын иргэний эрх борлуулсны орлогын дансанд тус тус төвлөрүүлсэн нь өмнөх оноос 62 нэгж талбар буюу 28.5 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

<sup>15</sup> хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газар, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх төрлийн соёлын байгууллагыг болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг байгаль, түүх, соёлын дурсгалт зүйл, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалах, хамгаалахад зориулан эзэмшиж, ашиглаж байгаа газрынх нь,

<sup>16</sup> төрийн болон орон нутгийн өмчийн асрамжийн болон бүх шатны боловсролын байгууллагыг улсын тусгай хамгаалалттай газраас бусад газар дахь эзэмшиж, ашиглаж буй газрынх нь

<sup>17</sup> Газрын төлбөрийн асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ газрын төлбөрийн ногдуулалтын жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд тушааж, ногдуулалтын эцсийн тооцоог хийнэ.

<sup>18</sup> Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлсэн бол орлого олсон гэж үзэж, орлогын хэмжээг дуудлага худалдааны анхны үнээс багагүй байхаар тооцно.

<sup>19</sup> Эцсийн эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийг борлуулах, шилжүүлэх замаар Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу олгосон газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг бүрэн буюу хэсэгчлэн борлуулах, шилжүүлэхтэй холбогдон олсон орлогыг тухайн эрх эзэмшигч аж ахуйн нэгжийн энэ хуулийн 10.1.2-т заасан орлогод тооцно.

<sup>20</sup> Газар эзэмших, ашиглах эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого.

**Хүснэгт№8 Эрх шилжүүлсний орлогыг өмнөх онтой харьцуулалт /мян.төг/**

Сумын нэр	2023 он		2024 он		Зөрүү	
	Нэг талбарын тоо	Эрх борлуулсны орлого	Нэг талбарын тоо	Эрх борлуулсны орлого	Нэг талбарын тоо	Эрх борлуулсны орлого
Баян-Агт	5	679.76	3	598.56	(2)	(81.2)
Бугат	182	26,828.76	193	27,539.72	11	711.0
Бүрэгхангай	2	527.50	2	600.00	-	72.5
Гурванбулаг	7	632.21	5	274.26	(2)	(357.9)
Дашинчилэн	2	220.00	3	168.80	1	(51.2)
Могод	3	2,941.77	5	241.02	2	(2,700.7)
Орхон	206	11,174.06	218	21,118.16	12	9,944.1
Рашаант	16	6,482.90	8	2,604.39	(8)	(3,878.5)
Сайхан	5	563.10	2	530.00	(3)	(33.1)
Сэлэнгэ	29	6,137.61	64	24,277.20	35	18,139.6
Тэшиг	3	1,382.45	9	1,221.04	6	(161.4)
Хангал	85	5,873.32	85	12,906.83	-	7,033.5
Хишиг-Өндөр	5	241.07	7	1,017.25	2	776.2
Хутаг-Өндөр	30	6,909.11	31	5,500.18	1	(1,408.9)
Хялганат тосгон	3	101.19	10	671.73	7	570.5
<b>Нийт дүн</b>	<b>583</b>	<b>70,694.83</b>	<b>645</b>	<b>99,269.13</b>	<b>62</b>	<b>28,574.3</b>

Эх сурвалж: Газрын цахим мэдээллийн нэгдсэн сан

2.26 Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд 2024 онд хэсэгчлэн 57, эрхээ бусдад шилжүүлсэн 735 нэгж талбарын газар шилжүүлсэн нь бүртгэгдсэн бол өмнөх оноос хэсэгчлэн 3, эрхээ бусдад шилжүүлсэн 81 нэгж талбар газраар өссөн үзүүлэлттэй байна.

2.27 Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2<sup>21</sup>-д төрийн байгууллага нь газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх, дамжуулан ашиглуулахыг хориглосон байхад өөрийн эзэмшил газрын гэрчилгээг бусдад шилжүүлсэн байна. Тухайлбал:

- Аймгийн Засаг даргын 2023 оны А/368 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын Тамгын газар (РД:9012419)-ын 6308007428 нэгж талбар бүхий нийтийн орон сууцны зориулалтаар эзэмшиж буй 5817 м<sup>2</sup> газраас 837 м<sup>2</sup> газрыг нийтийн эзэмшлийн талбайгаас 275 м<sup>2</sup> газар нийт 1112 м<sup>2</sup> газрыг албан конторын зориулалтаар Тагнуулын ерөнхий газрын Булган аймаг дахь хэлтэст шилжүүлсэн,
- Аймгийн Засаг даргын 2023 оны А/548 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын Тамгын газар (РД:9012419)-ын 6308008890 нэгж талбарын дугаартай газраас 200 м<sup>2</sup> газрыг аймгийн ИТХ-ын 2022 оны IX/19 дүгээр тогтоолоор баталсан Булган сумын шинэчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр авто зам төлөвлөгдсөн тул газрын байршлыг Төрийн банкны баруун талд байршил өөрчилж, иргэн Ж.Батжаргалд шилжүүлсэн,

<sup>21</sup> Энэ хуулийн 35.1.4, 35.1.6-д заасан эрх төрийн байгууллагад хамаарахгүй.

- Аймгийн Засаг даргын 2024 оны А/194 дүгээр захирамжаар аймгийн Засаг даргын Тамгын газар (РД:9012419)-ын 6308009557 нэгж талбар бүхий нийтийн орон сууцны зориулалтаар эзэмшиж буй 11677 м<sup>2</sup> газраас 98 м<sup>2</sup> газрыг “Төрийн банк” (РД:5341469)-д газрын дуудлага худалдаа зохион байгуулаагүй, нөхөн төлбөр олгох хуулийн зохицуулалтыг хэрэглээгүй шилжүүлсэн;

2.28 Аймгийн Засаг даргад газрын харилцааны талаар хуулиар өөрт олгогдоогүй Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.2<sup>22</sup>-т заасан Нийслэлийн засаг даргын бүрэн эрхийн заалтаар дараах захиргааны акт гаргасан байна. Тухайлбал:

- Газрын нэгж талбарын хэмжээ өөрчлөх 2023 онд А/39, А/80, А/109, А/392, А/534, А/546, А/548, А/634, А/741, 2024 онд А/57, А/423, А/620, А/675, А/740 захирамж;
- Газрын нэгж талбарын зориулалт өөрчлөх 2023 онд А/314, А/381, 2024 онд А/214 дүгээр захирамж;

2.29 Газар эзэмших эрх шилжүүлэх болон өвөлжөө, хаваржааны зориулалтаар олгогдсон нэгж талбар газрын гэрээний хугацаа сунгагдахгүй, шилжүүлэн авсан эзэмшигчид шилжүүлэх явц удаашралтай байгаа нь газрын хянан баталгаа хийлгэхэд мэргэжлийн байгууллага цөөн, ажиллах хүчний хүрэлцээ хангалтгүй, хугацаа ихээр зарцуулагддаг зэрэг хүчин зүйлээс нөлөөлсөн байна.

### **БҮЛЭГ 3. ГАЗАР ОЛГОЛТ, ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ОРЛОГОД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

*Газрын мэдээллийн системийн ашиглах талаар иргэд, олон нийтэд танилцуулга, сурталчилгааг тогтмол хийх шаардлагатай байна.*

3.1 Газрын мэдээллийн системийг 2016 оноос нэвтрүүлж эхэлсэн бөгөөд уг системээс хаягийн мэдээллийн систем, газар зохион байгуулалт төлөвлөлтийн цахим систем, газрын кадастрын систем, газрын үнэлгээний систем зэрэг 4 үндсэн дэд системүүдийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.

3.2 Улсын хэмжээнд нийслэл, 21 аймаг, бүх сум, дүүргийг хамарсан, бусад газрын харилцаатай холбогдох байгууллагуудтай холбогдсон Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” программ хангамжид суурилсан газрын кадастрын мэдээллийн санг холбосон мэдээлэл дамжуулах сүлжээ болон газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийн нэгдсэн нэг стандарттай мэдээлэл бүхий системийг бий болгосон байна.

3.3 Газрын нэгдмэл сангийн цаасаар гаргасан тайлан, улсын газрын нэгдмэл сангийн тайлан, цахим системд оруулсан тайлангийн тоон үзүүлэлтүүд хоорондоо зөрүүтэй, газрын нэгдмэл сангийн системд оруулах зарим мэдээлэл дутуу, эсвэл зарим мэдээллийн шийдвэр нэг байхад хариуцах эзний төлөв байдал зөрүүтэй эсвэл байхгүй зэрэг зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд гэрээний зарим нэр төрлийн мэдээлэл буюу гэрээний төлөв 204, регистрийн дугаар, иргэн

<sup>22</sup> батлагдсан төлөвлөгөөний дагуу тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, зориулалт, хэмжээг тогтоох;

хуулийн этгээдийн нэр 220, гэрчилгээний дугаар 19695, талбайн хэмжээ, зориулалт 222, газрын төлбөр 2895, гэрээний эхлэх огноо 203, дуусах огноо 462, өргөдлийн дугаар 221, нэгж талбарын дугаар 251, бүртгэсэн огноо 2420, бүртгэсэн албан хаагчийн нэр 2429 мэдээллийг хоосон байдлаар дутуу бүртгэсэн;

- Зарим нийтийн эдэлбэр газар болон, нөхөн сэргээх хамгаалах газрын эрхийн төлөвийн мэдээлэл байхгүй;
- Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлэх арга хэмжээний эрхийн төрлийг “эзэмших”-ээр сонгосон (Баяннуур сум-2710045, 2710048 дугаартай 2 нэгж талбар);
- Могод, Рашаант, Баян-Агт сумын 2024 оны төсөл сонгон шалгаруулалтын мэдээлэл системд ороогүй;
- Сумын ИТХ-аар батлуулсан нэгж талбар төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийн нэгж талбарын тоо хоорондоо зөрүүтэй (2023 онд аймгийн хэмжээнд нийт 5900 нэгж талбар өмчилж эзэмшүүлэхээр төлөвлөгдсөн байх бөгөөд төлөвлөгөөний биелэлт дээрх төлөвлөлтийн нэгж талбарын тоо 5765 нэгж талбар);

3.4 Газрын кадастрын мэдээллийн санд аудитын хамрах хугацаанд нийт 9888 өргөдөл бүртгэгдсэнээс 56.2 хувь буюу 5561 өргөдлийг шийдвэрлэж, 4224 өргөдөл буюу 42.7 хувь нь шийдвэрлэгдээгүй байна.

3.5 Өргөдөл, хүсэлтийг шийдвэрлээгүй нийтлэг шалтгаан нь тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт шинээр газар эзэмших, өмчлөх хүсэлт гаргасан, бичиг баримтын зөрчилтэй, бичиг баримтын бүрдүүлэлт дутуу, хүсэлт ирүүлсэн газар бусдад олгогдсон газартай давхардсан, инженерийн шугам сүлжээ бүхий газар, авто замын зурвас газарт орсон, үерийн аман дээр газар эзэмших, өмчлөх, ашиглах хүсэлт гаргасан, эзэмшиж байгаа газраа өмчлөхөөр хүсэлт гаргасан боловч газрын кадастрын мэдээллийн санд кадастрын зураг нь бодит хашаалсан газрын хэмжээнээс зөрүүтэй зэрэг шалтгаанаас өргөдөл, хүсэлтийг шийдвэрлээгүй байна.

3.6 Цахим систем нь газар олголтын ил тод байдлыг сайжруулсан гэж үзэж байна уу гэсэн асуултад 28.6 хувь нь тийм, 35.7 хувь нь мэдэхгүй, 35.7 хувь нь үгүй гэж хариулсан.

3.7 Цахим системийг ашиглахад хялбар байдлыг үнэлнэ үү гэсэн асуултад 7.1 хувь нь маш хялбар, 28.6 хувь нь харьцангуй хялбар, 42.9 хувь нь хэцүү, 21.4 хувь нь маш хэцүү гэж хариулсан.

Цахим системд сайжруулах шаардлагатай зүйл байна уу гэсэн асуултад дараах саналуудыг өгсөн байна. Үүнд:

- Цахим систем их гацдаг. Хурдыг нь сайжруулах шаардлагатай
- Цахим системээр хэдэн хүн, хаана газар эзэмшихээр хүсэлт гаргасан, миний хүсэлт хэддүгээрт шийдэгдэхээр байгаа, олгосон газрууд хаана, хэзээ олгогдсоныг ил тод харуулдаг болгох
- Мөн эзэмшихээр газар авчхаад худалдан борлуулж өөр хүнд шилжүүлснийг тодорхой системд бүртгэж харуулдаг болгох
- Сурталчилгаа, сургалт хийх

- Өргөдөл өгсөн дарааллаар ил тод нээлттэй болгох
- Газрын даамалгүй суманд газрын даамалтай болгох
- Дуудлага худалдаагаар болон үйлчилгээний зориулалтаар олгосон газрыг иргэдэд нээлттэй танилцуулж байх хэнд, хэзээ, ямар зориулалтаар, хэдэн төгрөгөөр ямар шалгуураар олгосон нь тодорхой бус байна
- Газар эзэмших ашиглах, өмчлөх мэдээлэл хангалттай хүрэхгүй байна
- Хөрсний шинжилгээ хийх нэрийдлээр мөнгө цаг хугацаа их орж байна.

3.8 Санал асуулгаас дүгнэхэд иргэдэд газар эзэмшүүлэх болон, эзэмшүүлсэн талаар ил тод мэдээлэл, цахим системээс мэдээлэл хэрхэн авах талаар сургалт сурталчилгаа хийх, цахимаар өгсөн өргөдлийг хурдан шуурхай хариу өгөхөд анхаарч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

3.9 Иргэд газар эзэмших, өмчлөх эрх шилжүүлэхтэй холбоотой өргөдлийг цахимаар илгээх туршлага, мэдлэг хангалтгүй, ихэнх тохиолдолд цахим систем ажиллах боломжгүй байдаг, системд хандахад ачаалал ихтэй зэрэг нөхцөл байдлыг ашиглан зарим нэг газрын харилцааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж хууль эрхзүйн үндэслэлгүй, захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөрсдөө дур мэдэн иргэдээс төлбөр, хураамж авч иргэдийн цахим хүсэлтийг газрын нэгдсэн цахим мэдээллийн санд илгээх үйлчилгээ үзүүлж байгаад анхаарал хандуулж, иргэдийн хэрэгцээ шаардлагыг харгалзан хууль эрх зүйн орчин нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

***Зарим сумууд газартай холбоотой зөрчлийг арилгах арга хэмжээг тодорхой түвшинд хэрэгжүүлэн ажиллаж байна.***

3.10 Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 “Газрын нэгдмэл санг эзэмших, ашиглах, хамгаалах болон газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд ... аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дагуу хяналт тавина” гэж заасан ч ихэнх сумын ИТХ, Засаг дарга нар хяналт тавьж ажилласан талаар тайлан мэдээлэл байхгүй байна.

3.11 Хангал, Орхон сум 2025 онд газрын нэгдсэн тооллого, бүртгэл, судалгаа хийх газрын зөрчлийг арилгах зорилгоор ажлын хэсэг томилон холбогдох иргэд, аж ахуй нэгж байгууллагад мэдэгдэл хүргүүлэн ажиллаж байгаа нь бусад сумууд хэрэгжүүлэх сайн туршлага болжээ.

3.12 Газрын төлбөрийн тухай хуулийн 4<sup>23</sup> -д заасны дагуу Аймгийн Татварын газраас 2025 онд Газрын төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахаар хийсэн хяналт шалгалтын үр дүнд дараах зөрчилд газрын төлбөрийг нөхөн ногдуулж, орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж ажилласан байна. Тухайлбал:

- Хяналт шалгалтын явцад “Бүрдэл майнинг” ХХК, Цагаан уулын магнит, Бэрхийн нурамт, Хос хас ХХК-уудын нийт 78.5 сая төгрөг;
- Газар эзэмших гэрээний хугацаа дууссан, сунгагдаагүй шалтгаанаар Монполимет, Өгөөж баян хангай, ГБНБ, Нарангоулд, Тэргүүн майнинг,

<sup>23</sup> 4.Татварын алба Татварын ерөнхий хуулийн дагуу газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтөд хяналт тавина.

Хамтын эх булаг ХХК-ийн 2023-2024 оны нийт 122.0 сая төгрөгийн орлогыг нөхөн ногдуулах шийдвэрийг гаргаж хүргүүлсэн;

3.13 Газрын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл орж газрын төлбөр ногдсон 8 татвар төлөгчийн 10 нэгж талбар газрын 2021-2023 оны нийт 508.7 сая төгрөгийн газрын төлбөрийн ногдлыг Бүрэгхангай сумын Засаг даргын захирамжаар газар ашиглах захирамж гараагүй гэх шалтгаанаар цуцалж, ногдлоос хассан, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй 33 аж ахуйн нэгжийн 47 нэгж талбар газарт 2021-2024 оны газрын төлбөрийн ногдол оруулаагүй зэрэг зөрчлүүдэд сумын Засаг дарга, холбогдох яаманд уламжлах ажлыг хамтран зохион байгуулах шийдвэрийг гаргасан байна.

**Саналд өгсөн тайлбар:**

ГХБХБГ, Татварын газраас аудитын алдаа зөрчлийн нэгтгэлд ирүүлсэн санал тайлбарыг нягтлан үзэж саналтай холбоотой дараах тайлбарыг өгч байна.

**Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт:**

1. Аймаг, сумдын ИТХ-аар батлуулсан жилийн төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөний биелэлттэй холбоотой илэрсэн асуудалд аудитын тайланд сумын ИТХ, Засаг даргад зөвлөмж хүргүүлэхээр оруулсан бөгөөд газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар сумын газрын даамал байхаар зохицуулагдсан байдаг. Мөн цахим системээс авсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөг дахин нягталж утга найруулгыг өөрчилсөн.
2. Аудитын тайланд зөрчлийн утга, сум, нэгж талбарыг алдаатай оруулсныг залруулсан. 2024 онд 2023 онд жимс жимсгэнэ тариалах газрыг өргөдлийн дагуу давуу эрхээр 0.8 га газрыг эзэмшүүлсэн. (Хангал сум)
3. Цахимаар ирүүлсэн мэдээллийг нягтлан шалгахад газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтэд малчдын хоршоонд газар эзэмшүүлэхтэй холбоотой төсөл сонгон шалгаруулалтын мэдээлэл байхгүй, хангалттай зохистой нотлох баримтыг ирүүлээгүй тул аудитын шийдвэрийг хэвээр үлдээлээ.
4. Аймгийн Засаг даргын захирамжаар 2023, 2024 онуудад иргэн, төрийн байгууллага, хуулийн этгээдэд холбогдох газар эзэмшүүлэхдээ газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгаагүйгээр эзэмшүүлсэн зөрчилд ирүүлсэн тайлбарт хангалттай зохистой нотлох баримт ирүүлээгүй тул аудитын шийдвэрийг хэвээр үлдээлээ.
5. Төсөл сонгон шалгаруулалттай холбоотой баримтыг аудитын явцад ирүүлэхийг тухайн сумдын газрын газрын даамал ирүүлээгүй тул саналыг хүлээн авах боломжгүй, харин нягтлан шалгах ажлыг зохион байгуулж хариу ирүүлэхийг сумдын ИТХ, ГХБХБГ-ын даргад зөвлөмжөөр хүргүүлсэн.
6. Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.2, 35 дугаар зүйлийн 35.2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй Аймгийн Засаг дарга хуулиар өөрт олгогдоогүй газрын зориулалт, хэмжээг өөрчлөх, төрийн байгууллагын эзэмшиж байгаа газрын эрхийг бусдад шилжүүлсэн зэрэг захирамж гаргасан зөрчилд таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлээ.
7. Газрын кадастрын мэдээллийн системд алдаа дутуу бүртгэгдсэн мэдээллийг аудитын тайлангийн хавсралтаар оруулсан.
8. Могод, Рашаант, Баян-Агт сумын 2024 оны төсөл сонгон шалгаруулалтын мэдээллийг газрын нэгдсэн системээс татаж ирүүлсэн мэдээллийг нягтлан шалгахад газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтэд малчдын хоршоонд газар эзэмшүүлэхтэй холбоотой төсөл сонгон шалгаруулалтын мэдээлэл байхгүй байгаа тул аудитын шийдвэрийг хэвээр үлдээлээ.
9. Сумын ИТХ-аар батлуулсан нэгж талбар төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийн нэгж талбарын тоо хоорондоо зөрүүтэй мэдээллийг тайланд тодорхой жишээтэйгээр нэгтгэн орууллаа.
10. Зарим нийтийн эдэлбэр газар болон, нөхөн сэргээх хамгаалах газрын эрхийн төлөвийн мэдээлэл нь зарим сумдын хувьд оруулсан, оруулаагүй зэрэг

ялгаатай байгаа мөн хангалттай зохистой нотлох баримт ирүүлээгүй тул аудитын шийдвэрийг хэвээр үлдээлээ.

**Татварын газарт:**

1. Санал, тайлбарыг хүлээн авч асуудлын бүртгэлээс хассан.
2. Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д “ Газрын төлбөрийн асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ газрын төлбөрийн ногдуулалтын жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд тушааж, ногдуулалтын эцсийн тооцоог хийнэ.” гэж заасныг үндэслэн аудитын шийдвэрийг хэвээр үлдээж, өрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй гэсэн хэсэгт аудитын тайланд утга найруулгын засвар хийж залрууллаа.
3. Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-д “Татварын алба Татварын ерөнхий хуулийн дагуу газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтөд хяналт тавина.” гэж заасны дагуу холбогдох хяналтыг хэрэгжүүлэн гэж заасны дагуу аудитын шийдвэрийг хэвээр үлдээлээ.

**ДҮГНЭЛТ:**

***Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.***

1. Газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн төлөвлөсөн боловч жилийн төлөвлөгөө боловсруулахтай холбоотой иргэд, олон нийтийн бодит хэрэгцээнд тулгуурлан төлөвлөсөн гэх баримт бичиг хангалтгүй байна.
2. Газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний хэрэгжилт өмнөх оноос 2024 онд өмнөх оноос 31.6 хувиар буурч 47.4 хувьтай биелсэн байна.
3. Газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө болон төлөвлөгөөний биелэлтэд сумын ИТХ хуульд заасан холбогдох хяналт шалгалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
4. Гэр бүлийн хамтын хэрэгцээнд газар олгохдоо холбогдох хуульд заасан хэмжээнээс илүү хэмжээгээр 154 нэгж талбарт 234.3 га газрыг үнэ төлбөргүй эзэмшүүлсэн байна.
5. Өвөлжөө хаваржааны газрыг эзэмшүүлэхтэй холбоотой хуулийн нарийвчилсан зохицуулалт байхгүйгээс сумд 0.06-0.7 га газрыг иргэдэд харилцан адилгүйгээр эзэмшүүлж байна.
6. Иргэд давуу эрхээр газар эзэмшүүлэх, төсөл сонгон шалгаруулалтаар малчдын хоршоонд газар эзэмшүүлэхтэй холбоотой баримт бичиг хангалтгүй, зарим сумд холбогдох баримт материалыг ирүүлээгүй.
7. Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд ажилчдын зуслан, амралтын газар, амины орон сууц, төмс, хүнсний ногоо тариалах, тэжээлийн ургамлын усалгаагүй тариалан, жимс, жимсгэнийн усалгаагүй тариалан, зэрэг зориулалтаар 0.5-2.7 га хүртэл хэмжээгээр газрыг үнэ төлбөргүй албаны бус хэрэгцээнд эзэмшүүлсэн байна.
8. Төсөл сонгон шалгаруулалтын журмыг зөрчин 6 нэгж талбарт 310.1 га газрыг хуулийн этгээдэд эзэмшүүлсэн байна.
9. Малчдын хоршоонд эзэмшүүлсэн 31 нэгж талбарыг газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд төлөвлөөгүй олгосон байна.

10. Аймгийн Засаг даргын захирамжаар аудитын хамрах хугацаанд газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 15 нэгж талбарт газрыг шинээр эзэмшүүлэхээр захирамж гаргасан байна.
11. Эзэмшүүлэхээр олгосон газарт хуульд заасан хугацаанд зарим нэгж талбарыг ашиглаагүй, хөрөнгө оруулалт хийгдээгүй байна.
12. Аудитаар иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлэхээр олгосон газрын хэмжээ сунгасан, хуулийн хугацаанд хөрөнгө оруулалт хийгдээгүй, зөвшөөрөлгүй дур мэдэн хашаа, байшин барьсан зэрэг зөрчлүүд байна.
13. Газрын төлбөрийн орлогыг дутуу ногдуулснаас 362.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэх боломж алдсан байна.
14. Газрын төлбөрийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй, өрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, төрийн байгууллагууд хоорондын уялдаа холбоо муу ажиллаж байна.
15. Иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг бусдад шилжүүлэх шийдвэр гаргахдаа хуульд заасан татвар, хураамжийг бүрэн ногдуулаагүй, 159 нэгж талбар газрын эрх шилжүүлсний орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.
16. Аймгийн засаг дарга хуулиар өөрт олгогдоогүй эрхээр газрын нэгж талбарын хэмжээ өөрчилсөн 14, зориулалт өөрчилсөн 3 захирамж гаргасан байна.
17. Газрын кадастрын нэгдсэн системд бүртгэгдсэн өргөдлийн 42.7 хувь холбогдох бичиг баримтын шаардлага хангаагүй, хүсэлт гаргасан газар давхацсан, зөвшөөрөгдөөгүй газарт хүсэлт гаргасан зэрэг шалтгаанаар шийдвэрлэгдээгүй байна.
18. Иргэд олон нийтэд газрын цахим системийн талаар тогтмол мэдээлэл, сургалт сурталчилгаа хийх шаардлагатай байна.
19. Зарим сумд газар олголттой холбоотой зөрчлийг арилгах арга хэмжээг тодорхой түвшинд хэрэгжүүлэн ажиллаж байгаа сайн жишээ байна.
20. Хуулийн тодорхой зохицуулалт байхгүйгээс иргэдийн газар эзэмших, өмчлөх, эрх шилжүүлэхтэй холбоотой өргөдлийг кадастрын хувийн аж ахуй нэгж захиргааны зөвшөөрөлгүйгээр төлбөр хураамж авч цахим системд илгээж байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

#### **ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:**

1. Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд эзэмшүүлж, ашиглуулах газар болон өвөлжөө хаваржааны зориулалтаар олгох газрын хэмжээ, тухайн газрыг олгох арга зам, шалгуур, нөхцөл, төлбөр, хураамж ногдуулах эсэх зэрэг асуудлыг хууль тогтоомжид тодорхой тусгаагүйгээс хэрэгцээнээс илүү газар эзэмшүүлэх, зориулалт бус зарцуулах, илүү хэмжээгээр эзэмшүүлсэн газрыг бусдад үнэ төлбөргүй шилжүүлэх зэрэг эрсдэл үүсэж байгаад анхаарч холбогдох заалтыг тодорхой болгох санал оруулах;

## **ЗӨВЛӨМЖ:**

**Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:**

### **СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА НАРТ:**

1. Газрын тухай хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дагуу тавих хяналтыг сайжруулах үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх;

### **АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР-Т**

1. Газрын төлбөрийн орлогын төлөвлөлт болон гүйцэтгэлд анхаарч сумдын Засаг даргатай байгуулж буй гүйцэтгэлийн төлөвлөгөө биелэлттэй уялдуулан үнэлж, хэрэгжилтийг хангуулж ажиллах;
2. Газрын нэгдмэл санг эзэмших, ашиглах, хамгаалах болон газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх, сумдын засаг дарга гарт өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах;

### **СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ:**

1. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа холбогдох журамд нийцүүлэн судалгаа, тооцоонд үндэслэн холбогдох баримт бичгийн бүрдлийг ханган баримтжуулах;
2. Газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангуулахад бодлогын болон зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
3. Иргэнд давуу эрхээр газар эзэмшүүлэх шийдвэр гаргахдаа өргөдөл, хүсэлт, хавсралт материалын иж бүрдлийг онцгой анхаарч, үе шатны хяналтыг сайжруулах, эзэмшүүлэхээр олгосон газарт нягтлан шалгах ажлыг зохион байгуулж, зөрчилтэй асуудлыг шийдвэрлэх;
4. Газрын тухай хуулийн 33.1.2-д заасны дагуу сумын хэмжээнд олгосон газрын шийдвэрт хяналт шалгалт хийж зөрчлийг арилгах үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулах;

### **АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Ү.БЯМБАСҮРЭН-Д**

1. Сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хэрэгжилт, дуудлага худалдааны үр дүн, газрын төлбөрийн ногдуулалт, газар олголт зэрэгт тавих хяналтыг үр дүнтэй төлөвлөн хэрэгжүүлэх;
2. Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид болон иргэдэд Газрын тухай хууль тогтоомж, цахим мэдээллийн системийн талаар сурталчлах ажил, арга хэмжээ зохион байгуулах;
3. Газрын төлбөрийн ногдуулалт, гүйцэтгэлийг системд оруулсны дараа давхардлыг аймаг, сумын түвшинд шалган арилгах, газрын төлбөрийн ногдуулалт, эзэмшсэн газрын эрхийг бусдад шилжүүлэх шийдвэрийн төлбөрийн гүйцэтгэлийг аймгийн Татварын газрын мэдээлэлтэй тулган баталгаажуулах;

4. Газрын бүртгэл эрхлэх хөтлөх, газрын нэгдмэл сангийн тайлан, мэдээ гаргах үйл ажиллагаандаа тус аудитын тайланд тусгасан зөрчлүүдийг давтан гаргахгүй байх чиглэлээр нэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэн, хяналт хариуцлагыг сайжруулах;
5. Газрын харилцааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж хууль эрхзүйн үндэслэлгүй, захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөрсдөө дур мэдэн иргэдээс төлбөр, хураамж авч иргэдийн цахим хүсэлтийг газрын нэгдсэн цахим мэдээллийн санд илгээх үйлчилгээ үзүүлж байгаад дүгнэлт хийж, иргэдийн хэрэгцээ шаардлагыг харгалзан e- Mongolia буюу хурдан төвөөр үйлчлүүлэх чиглэлийг баримтлах;

#### **АЙМГИЙН ТАТВАРЫН ГАЗРЫН ДАРГА Д.ЛХАГВАСҮРЭН-д**

1. Газрын төлбөрийн ногдуулалт, гүйцэтгэлийг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэдээлэлтэй тулгаж зөрүүг арилгах, өрийн үлдэгдлийн эцсийн тооцоог хийж хэвших;
2. 2023, 2024 оны дутуу төвлөрүүлсэн газрын төлбөрийн орлогын биелэлтийг хангуулах;

-oOo-



3	A.2.1 Иргэдэд газар олгохгүй үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?	Давуу эрхээр эзэмшүүлсэн газар эзэмшүүлэхтэй холбоотой байдлыг иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлсэн тэмдэглэл, сумын Засаг даргад саналыг нэгтгэн хүргүүлсэн баримт, зарим сумдын тухайн иргэн холбогдох журамд заасан газар тариалангийн салбарт гуравас доошгүй жил ажиллах түүний урсгачин борлуулалтаас үндсэн орлогоо олж байгаа, түүнчлэн энэ салбарт өмнө нь гуравас доошгүй жил ажиллах урсгачин борлуулалтаас үндсэн орлогоо олдог байсан иргэн гэдгийг нотлох баримт байхгүй Бугат, Орхон, Могод сум	Зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана	Төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд олгох газрын зориулалтыг Газрын тухай хуульд тусгажсан заагаагүй Газрын тухай хуулийн 33.1.1 энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан болон төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газрыг эзэмшүүлэх тухай шийдвэрийг алмаг, сум, нийслэл дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлаар баталсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу алмаг, сум, нийслэлийн Засаг дарга, сум, сумдын Засаг дарга, сумдын Засаг дарга	Хүлээн зөвшөөрсөн тул харуу тайлбар байхгүй
4	A.2.2 Газар эзэмшүүлж, ашиглуулах шийдвэр, үйл ажиллагаа нь үр нөлөөтэй хэрэгжсэн үү?	Малчдын хорлоонд эзэмшүүлсэн 31 нэгж талбаргаас Тагаар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам-ын 2.1.3-д заасныг зөрчин 11 нэгж талбарт 45.3 га газрыг малчдын хорлоонд эзэмшүүлсэн /Могод, Рашаант, Банан-Арт/	Зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана	Хүлээн зөвшөөрсөн тул харуу тайлбар байхгүй	
5	B.1.1 Эзэмшүүлэхээр олгосон газрыг хуульд заасан хугацаанд ашиглах, хөрөнгө оруулалт хийгдсэн үү?	Аймгийн Засаг даргын захирамжаар газар зохион байгуулалтын жилийн амжилтын төсөвт газрыг эзэмшүүлсэн 2024 онд Орхон нутгийн өмчийн газарт А/648, иргэн Б.Амарзүлэйд А/423, 4 төрийн байгууллагад А/738, 2023 онд, Булган аймгийн мурд А/246, иргэн П.Хишгэлдаад А/478, иргэн Э.Намаава, Ц.Бэчигчиг, М.Энхтүвш, А/711, Дэлгэдрэгэн Х.ХХ, иргэн Н.Дэмчигсүрэн, С.Зоригбаатар нарт А/815, Шүүгийн шийдвэр гүйцэтгэх газарт А/819 тоот захирамжаар тус тус газар эзэмшүүлсэн/	Зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана	Хүлээн зөвшөөрсөн тул харуу тайлбар байхгүй	
6	B.1.2 Иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулахад олгосон газрыг зориулалтын дагуу эзэмшиж, ашигласан үү?	Нийтийн эдлэлээр газрын төлөвлөгөөт /нэгж талбарт 2762.4 га газар ердийн хадлангийн газар ашиглуулахад төлөвлөж иргэдэд ашиглуулахаар гэрээ байгуулж ажиллаж байгаа нь /Газрын тухай хуулийн 52.6 /Бургалангай сум дахь эвэлтэй хэрэгжүүлж амжилгүй	Зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана	Хүлээн зөвшөөрсөн тул харуу тайлбар байхгүй	
7	B.2.1 Эзэмшүүлэхээр олгосон газрыг хуульд заасан хугацаанд ашиглах, хөрөнгө оруулалт хийгдсэн үү?	Төсөл сонгон шалгаруулахтай холбоотой төсөл хүлээн авсан, шалгаруулалтыг зохион байгуулалтын холбоотой ажил хэргийг зохион байгуулж, өмнөх жилд хурлын гэмдэглэл, малчдын хорлоонд ажиллаж, өмнөх жилд иргэдийн төлөөлөгчдийн Хурлаар баталсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу алмаг, сум, нийслэлийн Засаг дарга, сумдын Засаг дарга, сумдын Засаг дарга	Зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана	Хүлээн зөвшөөрсөн тул харуу тайлбар байхгүй	
8	B.2.2 Газрын төлбөрийн орлогыг төсөвт бүрэн будруулж байна үү?	Эмийн болон гоёлын ургамлын урсгалыг тариалангийн газрыг дурдлага худалдаагаар олгох газрыг ердийн дагуу давуу эрхээр олгосон /Сэлэнгэ сум 6302007350/	Зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана	Хүлээн зөвшөөрсөн тул харуу тайлбар байхгүй	
9	B.2.3 Иргэн, хуулийн этгээдийн газар эзэмшиж, ашиглах эрхийг бусдад шилжүүлж шийдвэр хэрэгжүүлсэн үү?	Иргэн, хуулийн этгээд зориулалтын дагуу хоёр жил дараалан ашиглаагүй, хөрөнгө оруулалт хийгээгүй, зөвшөөрөлгүй газар дүр мэдэн барилга байгуулах барьсан 245 нэгж талбар байна /Банан-Арт сум 56, Булган сум 133, Орхон сум 47, Хишиг-Өндөр сум 9, Ташиг сум 13, Бугат сум 36, Хангал сум 61 нэгж талбар газар	Зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана	Хүлээн зөвшөөрсөн тул харуу тайлбар байхгүй	
10	B.2.4 Газрын төлбөрийн орлогыг төсөвт бүрэн будруулж байна үү?	Мөн эзэмшил газрыг зөвшөөрөлгүй сунгасан, захирамж, гэрээлгээний хэмжээ зөрчин, мэдээллийн санд мэдээлэл дүүг бүртгэсэн эзэр 186 нэгж талбар газар байна /Орхон сум 109, Хангал сум 20, Бугат сум 48, Бургалангай сум 11, Банан-Арт сум 2, Ташиг сум 6, Хутаг-Өндөр сум 16, Хишиг-Өндөр сум 11, Могод сум 3 нэгж талбар газар	Зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана	Хүлээн зөвшөөрсөн тул харуу тайлбар байхгүй	
11	B.2.5 Газрын төлбөрийн орлогыг төсөвт бүрэн будруулж байна үү?	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын төлбөрийг нэвтрүүлж, ТНЦ183 талбарт, Төрийн газрын төлбөрийн үндэслэл 2023 онд 534.6 сая, 2024 онд 52.8 сая төгрөгөөр зөрүүтэй, ерийн үлдэгдлийг тооцоо хийлсэн актгаар батлагдаж байгаагүй.	Зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана	Хүлээн зөвшөөрсөн тул харуу тайлбар байхгүй	
12	B.2.6 Газрын төлбөрийн орлогыг төсөвт бүрэн будруулж байна үү?	Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-д төрийн байгууллага нь газар эзэмшиж эрийн гэрээлгээг бусдад шилжүүлж, дамуулан ашиглуулахыг хориглоосон байхад өмийн эзэмшил газрын гэрээлгээг бусдад шилжүүлсэн	Зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана	Хүлээн зөвшөөрсөн тул харуу тайлбар байхгүй	

<p>Бүрэн ногдуулж, төсөвт бүрэн төвлөрүүлсэн үү?</p>	<p>Газар нэгдмэл сангийн цөхмийг нэгдсэн системд эзэмших эрхийг өгөх, сумдын Засаг дарга захирмаар 2023 онд 125, 2024 онд 146 нэгж талбар газрыг бүсдэд шилжүүлэх шийдвэр гарсан байхад, шилжүүлэн авсан иргэн, хуулийн этгээд эрх шилжүүлсний төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсн үү.</p>	<p>Хүлээн зөвшөөрсөн тул харуу тайлбар байхгүй</p>	<p>Хүлээн зөвшөөрсөн тул харуу тайлбар байхгүй</p>
<p>Бүрэн ногдуулж, төсөвт бүрэн төвлөрүүлсэн үү?</p>	<p>Гарын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 д- төрийн байгууллага нь газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бүсдэд шилжүүлж, дамжуулан өмчлүүлснийг хориотойсон байхад, өөрийн эзэмшил газрын гэрчилгээг бүсдэд шилжүүлсэн.</p>	<p>Албан шавдлага хүргүүлэх</p>	<p>Албан шавдлага хүргүүлэх</p>
<p>Бүрэн ногдуулж, төсөвт бүрэн төвлөрүүлсэн үү?</p>	<p>Алмийн Засаг даргад газрын харилцааны талаар хуулиар өөрт олгогдосныг Гэрэн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.2-т заасан Нийслэлийн засаг даргад олгогдсон бүрэн эрхийн залтгаар дараах захирааны акт гаргасан.</p>	<p>Зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана</p>	<p>Зөвлөмж хүргүүлэх</p>
<p>Бүрэн ногдуулж, төсөвт бүрэн төвлөрүүлсэн үү?</p>	<p>Гарын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цөхмий системд бүртгэгдсэн эзэмшүүлэхээр олгосон газрын мэдээлэл дутуу, цөхмий мэдээллийн сангийн бүрдүүлэлт хангалтгүй.</p>	<p>Зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана</p>	<p>Хүлээн зөвшөөрсөн тул харуу тайлбар байхгүй</p>
<p>Бүрэн ногдуулж, төсөвт бүрэн төвлөрүүлсэн үү?</p>	<p>Гарын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цөхмий системд гэрээний зарим нэр төрлийн мэдээлэл буюу гэрээний төлөв 204, регистрийн дугаар, иргэн хуулийн этгээдийн нэр 220, гэрчилгээний дугаар 19895, талбайн хэмжээ, зориулалт 222, газрын төлбөр 2895, гэрээний зөвлөх олоо 203, дуусах олоо 462, өрсөлдлийн дугаар 221, нэгж талбарын дугаар 251, бүртгэгдсэн олоо 2420, бүртгэгдсэн албан хаагчийн нэр 2429 мэдээллийг хосон байрлаар дутуу бүртгэсэн.</p>	<p>Зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана</p>	<p>Хүлээн зөвшөөрсөн тул харуу тайлбар байхгүй</p>
<p>Бүрэн ногдуулж, төсөвт бүрэн төвлөрүүлсэн үү?</p>	<p>Гэр бүлийн хоргоцоний зориулалтаар шинээр өмчлүүлэх арга хэмжээний эрхийн төрлийн "эзэмшиж" зар олгосон Баянмүр сум-2710045, 2710048 дугаартай 2 нэгж талбар</p>	<p>Зөвлөмж хүргүүлэх</p>	<p>Хангалттай зохицотой нотлох баримтыг ирүүлсн үү тул аудитын шийдвэрийг хязгар үлдээгээ</p>
<p>Бүрэн ногдуулж, төсөвт бүрэн төвлөрүүлсэн үү?</p>	<p>Могод, Рашаант, Баян-Агт сумын 2024 оны төсөл сонгон шалгаруулалтын мэдээлэл системд ороогүй.</p>	<p>Зөвлөмж хүргүүлэх</p>	<p>Цохиомаар ирүүлсэн мэдээллийг нягтлан шалгахад газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтэд магнагчдын хориононд газар эзэмшүүлэхэд холбогтой төсөл сонгон шалгаруулалтын мэдээлэл байхгүй байгаа тул аудитын шийдвэрийг хязгар үлдээгээ.</p>
<p>Бүрэн ногдуулж, төсөвт бүрэн төвлөрүүлсэн үү?</p>	<p>Сумын ИТХ-аар батлуулсан нэгж талбар төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийн нэгж талбарын тоо хорионоос зөрүгдэж</p>	<p>Зөвлөмж хүргүүлэх</p>	<p>Зөрүүтэй мэдээллийг аудитын тайланд тодорхой жишээтэйгээ нэмж оруулна</p>
<p>Бүрэн ногдуулж, төсөвт бүрэн төвлөрүүлсэн үү?</p>	<p>Зарим нийтийн захирбар газар болон, нөхөн сэргээх хамгаалах газрын эрхийн төлөвийн мэдээлэл байхгүй</p>	<p>Зөвлөмж хүргүүлэх</p>	<p>Зөрүүтэй мэдээллийг аудитын тайланд тодорхой жишээтэйгээ нэмж оруулна</p>

Нийт дүн

587.6

В.1.1. Газрын мэдээллийн системийн ашиглалт ил, тод үр нөлөөтэй байна уу?

## Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: "Иргэн хуулийн этгээтийн эзэмшлийн зориулалтаар олгосон газар, эзэмшилт, ашиглалтын үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл  
 Байгууллагын нэр: Татварын газар

Аудитын код: БУА-2025/34-ШТА-ГА

№	Аудитын чиглэл/ асуулт	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (сая.төг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
1	Б.2.1 Газрын төлбөрийн ногдуулалтыг бүрэн хийсэн үү?	Газрын төлбөрийн орлогыг төлөвөж, батлуулахдаа газрын нэгдмэл санд бүртгэгдсэн гэрээний дагуу ногдуулалтаас бус өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн дугуу төлөвөж байна.	269.5	Зөвлөмж хүргүүлэх	Хүлээн зөвшөөрсөн.	Зөвлөмж хүргүүлэх
2	Б.2.2 Газрын төлбөрийн орлогыг төсөвт бүрэн бүрдүүлж байна уу?	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын төлбөрийн ногдуулалтын ГНСТ-8 тайлан, Татварын газрын төлбөрийн нэхэмжлэлийг иргэн, хуулийн этгээдэд илгээж хураасан газрын төлбөрийн үлдэгдэл 2023 онд 534.8 сая, 2024 онд 52.8 сая төгрөгөөр зөрүүтэй, өрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулдаггүй байна.	587.6	Зөвлөмж хүргүүлэх	Хүлээн зөвшөөрсөн.	Зөвлөмж хүргүүлэх
3	Б.2.3 Иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг бусдад шилжүүлэх шийдвэр гаргахдаа хуульд заасан татвар, хураамжийг бүрэн ногдуулж, төсөвт бүрэн төвлөрүүлсэн үү?	Газар нэгдмэл сангийн цахим нэгдсэн системд эзэмших эрхийг аймаг, сумдын Засаг дарга захирамажаар 2023 онд 125, 2024 онд 146 нэгж талбар газрыг бусдад шилжүүлэх шийдвэр гарсан байхад, шилжүүлэн авсан иргэн, хуулийн этгээд эрх шилжүүлсний төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй.	-	Зөвлөмж хүргүүлэх	Хүлээн зөвшөөрсөн.	Зөвлөмж хүргүүлэх
			857.1			

Нийт дүн

**Газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө /2023, 2024/**

**Хасралт-1**

<b>Газрын зориулалт</b>	<b>Нэгж талбарын тоо</b>	<b>Талбайн хэмжээ [м2]</b>
11: Бэлчээр	1	30,065.00
2023	1	30,065.00
1101: Өвөл-хаврын бэлчээр	52	608,864,865.00
2023	30	489,267,915.00
2024	22	119,596,950.00
1102: Зун-намрын бэлчээр	15	282,962,084.00
2023	10	200,722,239.00
2024	5	82,239,845.00
1201: Ердийн хадлан	10	35,705,796.00
2023	3	8,081,589.00
2024	7	27,624,207.00
1302: Төмс, хүнсний ногооны усалгаатай тариалан	4	204,313.00
2023	3	105,087.00
2024	1	99,226.00
1304: Техникийн ургамлын усалгаатай тариалан	1	29,999.00
2023	1	29,999.00
1305: Жимс, жимсгэний усалгаатай тариалан	3	1,011,470.00
2023	1	10,198.00
2024	2	1,001,272.00
1401: Үр тарианы усалгаагүй тариалан	36	15,353,709.00
2023	9	5,080,764.00
2024	27	10,272,945.00
1402: Төмс, хүнсний ногооны усалгаагүй тариалан	53	1,028,391.00
2023	24	646,640.00
2024	29	381,751.00
1403: Тэжээлийн ургамлын усалгаагүй тариалан	143	11,155,157.00
2023	58	7,419,085.00
2024	85	3,736,072.00
1405: Жимс, жимсгэний усалгаагүй тариалан	196	1,318,486.00
2023	14	413,542.00
2024	182	904,944.00
1406: Эмийн болон гоёлын ургамлын усалгаагүй тариалан	2	31,588.00
2023	1	15,794.00
2024	1	15,794.00
1601: Өвөлжөө, хаваржаа	1006	3,967,657.00
2023	600	2,457,359.00
2024	406	1,510,298.00
1602: Мал эмнэлгийн үйлчилгээний цэг	6	21,342.00
2023	3	18,342.00
2024	3	3,000.00
1603: Үтрэм	6	62,982.00
2023	3	23,022.00
2024	3	39,960.00
1604: ХАА-н машин, механизмын хашаа, гараж	1	668.00
2023	1	668.00
1605: Тэжээл, бордооны агуулах	1	12,382.00
2024	1	12,382.00

1606: ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор	33	1,988,184.00
2023	25	1,937,707.00
2024	8	50,477.00
1607: Хүлэмж, дарлага	2	20,000.00
2023	2	20,000.00
1610: Бэлчээр дэх уст цэг	34	92,513,553.00
2023	19	62,527,080.00
2024	15	29,986,473.00
1611: Зоорь, ХАА-н бүтээгдэхүүн хадгалах газар	3	6,702.00
2024	3	6,702.00
1613: Эрчимжсэн мал аж ахуйн ферм	11	225,060.00
2023	3	79,691.00
2024	8	145,369.00
1616: Зөгийн аж ахуй	1	20,000.00
2024	1	20,000.00
1623: Мал аж ахуйн үйлдвэрлэл	11	116,881.00
2024	11	116,881.00
1624: Мал аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалалт	28	1,317,055.00
2024	28	1,317,055.00
2101: Төрийн захиргааны байгууллага	16	22,997.00
2023	6	13,933.00
2024	10	9,064.00
2104: Боловсролын байгууллага	6	28,446.00
2023	2	11,722.00
2024	4	16,724.00
2106: Банк, санхүүгийн байгууллага	3	1,021.00
2023	1	537.00
2024	2	484.00
2108: Нам, олон нийтийн байгууллага	1	520.00
2023	1	520.00
2109: Сүм, хийд, шашны байгууллага	2	10,210.00
2023	1	210.00
2024	1	10,000.00
2111: Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	107	219,940.00
2023	57	87,423.00
2024	50	132,517.00
2113: Музей, түүх, соёлын дурсгалт газар	3	168,055.00
2023	2	160,912.00
2024	1	7,143.00
2116: Автомашины гараж	6	812.00
2023	5	495.00
2024	1	317.00
2117: Шатахуун түгээх газар, агуулах	9	34,004.00
2023	5	16,439.00
2024	4	17,565.00
2118: Ус түгээх цэг	1	501.00
2024	1	501.00
2120: Асрамжийн газрын барилга байгууламж	1	5,000.00
2023	1	5,000.00
2122: Нийтийн үйлчилгээний байгууллага	1	524.00
2024	1	524.00
2202: 5-8 давхар нийтийн орон сууц	1	5,000.00
2024	1	5,000.00
2203: 4 ба түүнээс доош давхар нийтийн орон сууц	7	11,203.00
2023	3	2,800.00

2024	4	8,403.00
2204: Амины орон сууц	41	129,461.00
2023	23	78,421.00
2024	18	51,040.00
2205: Гэр, орон сууцны хашааны газар	2920	3,602,865.00
2023	1798	2,121,386.00
2024	1122	1,481,479.00
2206: Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар	4010	2,609,192.00
2023	2951	1,903,049.00
2024	1059	706,143.00
2302: Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар	7	39,909.00
2023	4	30,788.00
2024	3	9,121.00
2309: Хүнсний үйлдвэрлэл	2	1,328.00
2023	1	664.00
2024	1	664.00
2312: Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4	72,512.00
2023	3	46,256.00
2024	1	26,256.00
2316: Хог хаягдлын үйлдвэрлэл	1	867.00
2023	1	867.00
2402: Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт	10	266,679.00
2023	9	242,854.00
2024	1	23,825.00
2403: Цэнгэлдэх хүрээлэн, наадмын талбай	3	105,904.00
2023	2	55,903.00
2024	1	50,001.00
2404: Нэрэмжит талбай, хөшөө, дурсгалын газар	1	900.00
2023	1	900.00
2405: Тоглоомын талбай	10	16,637.00
2023	6	6,454.00
2024	4	10,183.00
2407: Хогийн цэг	3	15,200.00
2023	3	15,200.00
2408: Оршуулгын газар	7	622,171.00
2023	7	622,171.00
2501: Хүүхдийн зуслан	2	130,880.00
2023	1	10,000.00
2024	1	120,880.00
2502: Амралтын газар	72	1,015,250.00
2023	46	585,973.00
2024	26	429,277.00
2503: Аялал, жуулчлалын бааз	31	800,299.00
2023	5	220,733.00
2024	26	579,566.00
2504: Рашаан, сувилалын газар	10	223,222.00
2023	5	122,222.00
2024	5	101,000.00
2505: Биеийн тамирын зориулалттай гадаа талбай, спорты	2	278,957.00
2024	2	278,957.00
2601: Ашиглалт, олборлолт явуулж буй уурхайн талбай	4	5,988,694.00
2023	4	5,988,694.00
2606: Уурхайн суурьшлын бүс	1	12,279.00
2023	1	12,279.00
2701: Автозам	2	37,566.00

2023	1	18,783.00
2024	1	18,783.00
2702: Авто машины зогсоол	4	5,610.00
2023	4	5,610.00
3203: Хатуу хучилттай зам	28	24,617,384.00
2023	26	21,694,432.00
2024	2	2,922,952.00
3206: Авто замын сургалт, дадлагын талбай	1	4,000.00
2024	1	4,000.00
3401: Холбоо, мэдээлэл дамжуулах, хүлээн авах станц	2	200.00
2023	2	200.00
3401: Холбоо, мэдээлэл дамжуулах, хүлээн авах станц	14	5,410.00
2023	11	3,703.00
2024	3	1,707.00
3402: Эрчим хүч дамжуулах станц	5	7,124.00
2023	2	6,992.00
2024	3	132.00
3403: Газар дээрх дулаан дамжуулах хоолой	3	5,161.00
2023	3	5,161.00
3406: Ус түгээх, шахах, өргөх байгууламж	1	100.00
2024	1	100.00
3408: Цэвэр ус дамжуулах хоолой	1	5,077.00
2023	1	5,077.00
3409: Цэвэрлэх байгууламж, ариутгах татуурга	1	100.00
2023	1	100.00
3410: Цахилгаан, эрчим хүч дамжуулах шугам	9	186,913.00
2023	9	186,913.00
3411: Холбоо, мэдээлэл дамжуулах шугам	29	1,282,300.00
2024	29	1,282,300.00
4101: Ой модоор бүрхэгдсэн газар	4	425,847,965.00
2023	4	425,847,965.00
4103: Таримал ой, ойжуулалт хийгдэж буй газар	41	3,345,573.00
2023	15	584,792.00
2024	26	2,760,781.00
4104: Мод үржүүлгийн газар	48	1,554,216.00
2023	41	1,491,082.00
2024	7	63,134.00
5102: Булаг, шанд	1	20.00
2024	1	20.00
5201: Булаг, шанд	14	915,924.00
2023	10	915,612.00
2024	4	312.00
6501: ШУ, технологийн сорилт туршилт болон байгаль орч	3	355,119.00
2023	3	355,119.00
7401: Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих	1	19,370.00
2023	1	19,370.00
<b>Нийт дүн</b>	<b>9177</b>	<b>1,532,604,960.00</b>

**Газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний биелэлт /2023, 2024/**

**Хавсралт -1**

<b>Газрын зориулалт</b>	<b>нэгж талбар тоо</b>	<b>талбайн хэмжээ м2</b>
1101: Өвөл-хаврын бэлчээр	49	523,303,239.00
2023	27	403,706,289.00
2024	22	119,596,950.00
1102: Зун-намрын бэлчээр	15	282,962,084.00
2023	10	200,722,239.00
2024	5	82,239,845.00
1201: Ердийн хадлан	10	35,705,796.00
2023	3	8,081,589.00
2024	7	27,624,207.00
1302: Төмс, хүнсний ногооны усалгаатай тариалан	3	105,087.00
2023	3	105,087.00
2024		
1305: Жимс, жимсгэний усалгаатай тариалан	2	1,010,198.00
2023	1	10,198.00
2024	1	1,000,000.00
1401: Үр тарианы усалгаагүй тариалан	23	7,460,457.00
2023	8	5,061,009.00
2024	15	2,399,448.00
1402: Төмс, хүнсний ногооны усалгаагүй тариалан	31	772,627.00
2023	19	608,440.00
2024	12	164,187.00
1403: Тэжээлийн ургамлын усалгаагүй тариалан	128	8,461,093.00
2023	38	3,988,058.00
2024	90	4,473,035.00
1405: Жимс, жимсгэний усалгаагүй тариалан	124	922,332.00
2023	13	393,542.00
2024	111	528,790.00
1406: Эмийн болон гоёлын ургамлын усалгаагүй тариалан	2	31,588.00
2023	1	15,794.00
2024	1	15,794.00
1601: Өвөлжөө, хаваржаа	618	2,603,491.00
2023	383	1,713,066.00
2024	235	890,425.00
1602: Мал эмнэлгийн үйлчилгээний цэг	5	13,511.00
2023	2	10,511.00
2024	3	3,000.00
1603: Үтрэм	3	30,535.00
2023	1	10,575.00
2024	2	19,960.00
1604: ХАА-н машин, механизмын хашаа, гараж	1	668.00
2023	1	668.00
1605: Тэжээл, бордооны агуулах	1	12,382.00
2024	1	12,382.00
1606: ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор	12	1,801,643.00
2023	10	1,793,963.00
2024	2	7,680.00
1607: Хүлэмж, дарлага	1	10,000.00
2023	1	10,000.00

1610: Бэлчээр дэх уст цэг	25	64,598,191.00
2023	13	34,612,218.00
2024	12	29,985,973.00
1611: Зоорь, ХАА-н бүтээгдэхүүн хадгалах газар	3	6,702.00
2024	3	6,702.00
1613: Эрчимжсэн мал аж ахуйн ферм	8	184,382.00
2023	3	79,691.00
2024	5	104,691.00
1623: Мал аж ахуйн үйлдвэрлэл	2	29,990.00
2024	2	29,990.00
1624: Мал аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариа	12	539,228.00
2024	12	539,228.00
2101: Төрийн захиргааны байгууллага	15	22,361.00
2023	6	13,933.00
2024	9	8,428.00
2104: Боловсролын байгууллага	6	28,446.00
2023	2	11,722.00
2024	4	16,724.00
2106: Банк, санхүүгийн байгууллага	3	1,021.00
2023	1	537.00
2024	2	484.00
2108: Нам, олон нийтийн байгууллага	1	520.00
2023	1	520.00
2109: Сүм, хийд, шашны байгууллага	3	34,030.00
2023	2	24,030.00
2024	1	10,000.00
2111: Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбо	64	116,860.00
2023	36	38,766.00
2024	28	78,094.00
2113: Музей, түүх, соёлын дурсгалт газар	1	78,210.00
2023	1	78,210.00
2024		
2116: Автомашины гараж	6	812.00
2023	5	495.00
2024	1	317.00
2117: Шатахуун түгээх газар, агуулах	5	14,198.00
2023	3	8,200.00
2024	2	5,998.00
2202: 5-8 давхар нийтийн орон сууц	1	5,000.00
2024	1	5,000.00
2203: 4 ба түүнээс доош давхар нийтийн орон сууц	7	11,203.00
2023	3	2,800.00
2024	4	8,403.00
2204: Амины орон сууц	25	114,823.00
2023	22	64,421.00
2024	3	50,402.00
2205: Гэр, орон сууцны хашааны газар	1537	1,668,080.00
2023	1221	1,324,662.00
2024	316	343,418.00
2206: Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар	2813	1,787,285.00
2023	2280	1,451,125.00
2024	533	336,160.00
2302: Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар	4	32,646.00
2023	2	22,816.00
2024	2	9,830.00

2309: Хүнсний үйлдвэрлэл	2	1,328.00
2023	1	664.00
2024	1	664.00
2312: Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4	72,512.00
2023	3	46,256.00
2024	1	26,256.00
2316: Хог хаягдлын үйлдвэрлэл	1	867.00
2023	1	867.00
2402: Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, цэцэрлэгжүү	10	266,679.00
2023	9	242,854.00
2024	1	23,825.00
2403: Цэнгэлдэх хүрээлэн, наадмын талбай	3	105,904.00
2023	2	55,903.00
2024	1	50,001.00
2404: Нэрэмжит талбай, хөшөө, дурсгалын газар	1	900.00
2023	1	900.00
2405: Тоглоомын талбай	10	16,637.00
2023	6	6,454.00
2024	4	10,183.00
2407: Хогийн цэг	3	15,200.00
2023	3	15,200.00
2408: Оршуулгын газар	7	622,171.00
2023	7	622,171.00
2501: Хүүхдийн зуслан	1	120,880.00
2023		
2024	1	120,880.00
2502: Амралтын газар	42	586,117.00
2023	30	374,985.00
2024	12	211,132.00
2503: Аялал, жуулчлалын бааз	23	529,038.00
2023	3	60,735.00
2024	20	468,303.00
2504: Рашаан, сувилалын газар	1	2,222.00
2023	1	2,222.00
2024		
2505: Биеийн тамирын зориулалттай гадаа талбай, спорты	2	278,957.00
2024	2	278,957.00
2601: Ашиглалт, олборлолт явуулж буй уурхайн талбай	3	5,953,528.00
2023	3	5,953,528.00
2606: Уурхайн суурьшлын бүс	1	12,279.00
2023	1	12,279.00
2702: Авто машины зогсоол	4	5,610.00
2023	4	5,610.00
3203: Хатуу хучилттай зам	27	23,252,264.00
2023	25	20,329,312.00
2024	2	2,922,952.00
3206: Авто замын сургалт, дадлагын талбай	1	4,000.00
2024	1	4,000.00
3401: Холбоо, мэдээлэл дамжуулах, хүлээн авах станц	6	1,802.00
2023	6	1,802.00
2024		
3402: Эрчим хүч дамжуулах станц	2	6,908.00
2023	1	6,892.00
2024	1	16.00
3406: Ус түгээх, шахах, өргөх байгууламж		

2024		
3408: Цэвэр ус дамжуулах хоолой	1	5,077.00
2023	1	5,077.00
3409: Цэвэрлэх байгууламж, ариутгах татуурга		
2023		
3410: Цахилгаан, эрчим хүч дамжуулах шугам	3	68,036.00
2023	3	68,036.00
3411: Холбоо, мэдээлэл дамжуулах шугам	29	1,223,839.00
2024	29	1,223,839.00
4101: Ой модоор бүрхэгдсэн газар	4	425,847,965.00
2023	4	425,847,965.00
4103: Таримал ой, ойжуулалт хийгдэж буй газар	33	1,023,692.00
2023	10	388,762.00
2024	23	634,930.00
4104: Мод үржүүлгийн газар	35	1,027,877.00
2023	30	984,747.00
2024	5	43,130.00
5201: Булаг, шанд	10	2,534.00
2023	7	2,300.00
2024	3	234.00
6501: ШУ, технологийн сорилт туршилт болон байгаль орчи	3	355,119.00
2023	3	355,119.00
7401: Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих г	1	19,370.00
2023	1	19,370.00
<b>Нийт дүн</b>	<b>5842</b>	<b>1,395,910,031.00</b>

**Гэр бүлийн хамтын хэрэгцээнд хуульд заасан хэмжээнээс илүү хэмжээгээр төлөвлөсөн, эзэмшүүлсэн газар /2023, 2024/**

**хасвралт-2**

<b>Сумдын нэрс, газрын зориулалт</b>	<b>нэгж талбар тоо</b>	<b>талбайн хэмжээ м2</b>	<b>илүү олгосон талбайн хэмжээ</b>
<b>Бугат сум</b>	2	15,008.00	- 13,008.00
1405: Жимс, жимсгэний усалгаагүй тариалан	2	15,008.00	- 13,008.00
2023	1	10,000.00	- 9,000.00
-9000	1	10,000.00	- 9,000.00
2024	1	5,008.00	- 4,008.00
-4008	1	5,008.00	- 4,008.00
<b>Орхон сум</b>	1	22,984.00	- 21,984.00
1405: Жимс, жимсгэний усалгаагүй тариалан	1	22,984.00	- 21,984.00
2024	1	22,984.00	- 21,984.00
-21984	1	22,984.00	- 21,984.00
<b>Сэлэнгэ сум</b>	2	395,360.00	- 393,360.00
1405: Жимс, жимсгэний усалгаагүй тариалан	2	395,360.00	- 393,360.00
2023	1	197,680.00	- 196,680.00
-196680	1	197,680.00	- 196,680.00
<b>Тэшиг сум</b>	1	10,198.00	- 9,198.00
1305: Жимс, жимсгэний усалгаатай тариалан	1	10,198.00	- 9,198.00
2023	1	10,198.00	- 9,198.00
-9198	1	10,198.00	- 9,198.00
<b>Хангал сум</b>	1	8,860.00	- 7,860.00
1405: Жимс, жимсгэний усалгаагүй тариалан	1	8,860.00	- 7,860.00
2023	1	8,860.00	- 7,860.00
-7860	1	8,860.00	- 7,860.00
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>25,730.00</b>	<b>- 248,730.00</b>
<b>Баян-Агт сум</b>	1	1675997	-675997
2023	1	1675997	-675997
1403: Тэжээлийн ургамлын усалгаагүй тариалан	1	1675997	-675997
<b>Сайхан сум</b>	1	1648933	-648933
2023	1	1648933	-648933
1401: Үр тарианы усалгаагүй тариалан	1	1648933	-648933
<b>Хутаг-Өндөр сум</b>	1	1708434	-708434
2023	1	1708434	-708434
1401: Үр тарианы усалгаагүй тариалан	1	1708434	-708434
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>5033364</b>	<b>-2033364</b>
<b>Бугат сум</b>	41	30968	-17509
2023	29	19630	-7663
2205: Гэр, орон сууцны хашааны газар	27	18199	-7632
2206: Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар	2	1431	-31
2024	12	11338	-9846
2205: Гэр, орон сууцны хашааны газар	12	11338	-9846
<b>Булган сум</b>	26	12009	-269
2023	17	12009	-109
2204: Амины орон сууц	14	9886	-86
2205: Гэр, орон сууцны хашааны газар	3	2123	-23
2024	9		-160
2205: Гэр, орон сууцны хашааны газар	9		-160

<b>Орхон сум</b>	57	39213	-10064
2023	57	39213	-10064
2205: Гэр, орон сууцны хашааны газар	57	39213	-10064
<b>Сайхан сум</b>	2	1546	-1433
2023	1	1546	-846
2205: Гэр, орон сууцны хашааны газар	1	1546	-846
2024	1		-587
2205: Гэр, орон сууцны хашааны газар	1		-587
<b>Сэлэнгэ сум</b>	1	1064	-364
2023	1	1064	-364
2205: Гэр, орон сууцны хашааны газар	1	1064	-364
<b>Тэшиг сум</b>	15	10029	-29827
2023	9	10029	-19233
2205: Гэр, орон сууцны хашааны газар	9	10029	-19233
2024	6		-10594
2205: Гэр, орон сууцны хашааны газар	6		-10594
<b>Хангал сум</b>	1		-141
2024	1		-141
2205: Гэр, орон сууцны хашааны газар	1		-141
<b>Хутаг-Өндөр сум</b>	2	2946	-1546
2023	2	2946	-1546
2205: Гэр, орон сууцны хашааны газар	2	2946	-1546
<b>Нийт дүн</b>	<b>145</b>	<b>97775</b>	<b>-61153</b>

## Төрийн байгууллагын байгууллагад эзэмшүүлсэн газар

Д/д	Байгууллагын нэрс	Нэгж талбарын тоо	Газрын хэмжээ	Нэгж талбарын тоо /ногдуулаг таар/	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр				
					Гэрээгээр	Тухайн жил нийт	Урьд оны илүү, дутуу	төлсөн	Бүгд дүн
1	"Булган авто зам засвар арчлалт" ТӨХК	4	139,006.0		478.6	478.6	(195.1)		673.7
